6.3.Энэ журмын 4.5-д заасан үйлчилгээ үзүүлэх талууд болон дотоод үнэт цаасанд оролцогч талууд үйлчилгээний гэрээний хэрэгжилтийг хангаагүй, эсхүл гэрээний хэрэгжилтийг хангахдаа алдаа гаргасан, гэрээний үүргээ зөрчсөн нь үнэт цаас гаргах, арилжаалах үйл ажиллагаанд хамтран ажиллахгүй байх үндэслэл болно.

6.4.Үнэт цаас гаргах, арилжаалах үйл явцад энэ журмын 4.5-д заасан Ажлын хэсэг болон бусад байгууллага нь үнэт цаас гаргахтай холбоотой мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, задруулах, нийтэд ил болгосон тохиолдолд эрх бүхий албан тушаалтан болон бусад буруутай этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---о0о---



“Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам”-ын 1 дүгээр хавсралт

АНДЕРРАЙТЕР, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Үнэлэх үзүүлэлт	Санал	Оноо/Дүн
1. Үнэт цаас гаргах зөвлөгөө		
Валют		
Хугацаа		
Өрийн эргэн төлөлтийн хуваарьтай зохицсон байдал		
Санал болгож буй хүүгийн хэмжээний зохистой байдал		
Үнэ тогтоосон аргачлал		
Үйлчилгээний төлбөр		
Андеррайтинг хийх эсэх		
Үнэт цаас гаргах хугацааны зөвлөмж		
Танилцуулгын чанар, агуулга		
2. Өрийн зохицуулалтын санал (шаардлагатай тохиолдолд)		
Өрийн зохицуулалт хийж байсан туршлага		
Өрийн зохицуулалтын саналын чанар		
Техникийн үнэлгээ		
Үнийн стратегийн чанар		
Өрийн багцтай нийцэж байгаа эсэх		
Өрийн удирдлагын багийн хүчин чадал		
Олон улстай хамтран ажилласан туршлага (ижил түвшний эрсдэлийн үнэлгээтэй орон нутаг, Засгийн газар)		
Өрийн зохицуулалтыг ахлан ажиллаж байсан туршлага		
Франчайзын чанар		
Найдвартай байдал		
3. Хүчин чадал		
Санал болгож буй хөрөнгө оруулагчид		
Роудшоу хийсэн туршлага		
Төлөвлөсөн уулзалт хурлууд		
Олон улсын үнэлгээ		
Олон улстай хамтран ажилласан туршлага		



Төв: орон нутгийн, бүс нутгийн, олон улсын түвшинд ажилласан туршлага		
4.Зээл болон макро судалгаа		
Улс, эсхүл бүс нутгийг хамарсан байдал		
5.Эрсдэл үүрэх чадвар		
Нийслэлийн гадаад үнэт цаасыг анхдагч зах зээлд гаргах чадвар		
Нийслэлийн гадаад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн эргэц		
Дотоодын зах зээл дээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа		
6. Харилцаа		
Засгийн газрын нөхцөл байдлыг тогтмол судалсан байдал		
Засгийн газрын нөхцөл байдлыг судалсан хугацаа		
Шинэлэг байдал		
Өмнө нь өрийн зохицуулалтыг ахлан ажиллаж байсан туршлага		
Бусад үйлчилгээ		
Итгэл даах чадвар		
	Нийт дүн	

*\*Үзүүлэлт тус бүрийг 1-5 оноогоор үнэлэх бөгөөд 1 хамгийн бага, 5 хамгийн их гэсэн утгатайгаар үнэлнэ.*



“Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах,  
мэдээлэх журам”-ын 2 дугаар хавсралт

ХУУЛИЙН ФИРМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Үнэлэх үзүүлэлт	Санал	Оноо/Дүн
Үйлчилгээний төлбөр		
Шуурхай байдал		
Шинэлэг байдал		
Хамтран ажиллаж байсан олон улсын туршлага		
Хүний нөөцийн чадвар		
	Нийт дүн	

*\*Үзүүлэлт тус бүрийг 1-5 оноогоор үнэлэх бөгөөд 1 хамгийн бага,  
5 хамгийн их гэсэн утгатайгаар үнэлнэ.*

---o0o---

«**МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХуй**»-ийн Хүндэтгэсэн Зөвлөхөөс /Хүндэтгэсэн Зөвлөх /  
Хүндэтгэсэн Зөвлөх /  
Хүндэтгэсэн Зөвлөх /

Хүндэтгэсэн Зөвлөхөөс /Хүндэтгэсэн Зөвлөх /

Хүндэтгэсэн Зөвлөхөөс /Хүндэтгэсэн Зөвлөх /

Хүндэтгэсэн Зөвлөхөөс /Хүндэтгэсэн Зөвлөх /

Хүндэтгэсэн Зөвлөхөөс /Хүндэтгэсэн Зөвлөх /

Хүндэтгэсэн Зөвлөхөөс /Хүндэтгэсэн Зөвлөх /

Хүндэтгэсэн Зөвлөхөөс /Хүндэтгэсэн Зөвлөх /

Хүндэтгэсэн Зөвлөхөөс /Хүндэтгэсэн Зөвлөх /





дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр  
2005 он гэр тэгээн гэр 2005 он гэр  
2005 он гэр тэгээн гэр 2005 он гэр

дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр  
дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр

дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр

дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр  
дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр

дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр  
дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр

дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр

дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр  
дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр

дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр  
дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр

дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр  
дүрсэр гэр тэгээн гэр 2005 он гэр























«Будниг, Алдасууд, Хүндэтгэл, Гэрээний Төлөөлөгч, Алдасуудын Төлөөлөгч  
 Группын Компани» - г-ийн Хүндэтгэл, Алдасуудын Төлөөлөгч

Бусад гэрээний мөрдөлийн үндсэн дээр

Бүтээгчийн / Үйлдвэр	Бүтээгч	Бүтээгчийн мэдээлэл
		Бүтээгчийн мэдээлэл
		Бүтээгчийн мэдээлэл
		Бүтээгчийн мэдээлэл
		Бүтээгчийн мэдээлэл
		Бүтээгчийн мэдээлэл
		Бүтээгчийн мэдээлэл
		Бүтээгчийн мэдээлэл
		Бүтээгчийн мэдээлэл
	Бүтээгчийн мэдээлэл	

\*Бүтээгчийн мэдээлэл нь г-ийн бүтээгчийн мэдээлэл, г-ийн бүтээгчийн мэдээлэл, г-ийн бүтээгчийн мэдээлэл...

-----000-----



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2024 оны 11 дүгээр  
сарын 08-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар  
хот

### Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 17.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар, Л.Өлзийсайхан, О.Мөнхсайхан /илтгэгч/, Э.Энхтуяа, Ц.Цолмон, Б.Болдбаатар, Р.Батрагчаа нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Д.Оросоо болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нар оролцов.

Энэхүү хуралдаанаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсэг, Далдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан эцэслэн шийдвэрлэж, мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай” 30 дугаар тогтоолын үндэслэлийг хянан хэлэлцэв.

### **Нэг. Монгол Улсын иргэн Ж.Эрхэмбаатар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ:**

“Монгол Улсын Их Хурлаас 1997 оны 5 дугаар сарын 01-ний өдөр баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан байна.

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн

биелэлтэд “дээд” хяналт тавих эрх бүхий байгууллага. Үндсэн хуулийн биелэлтэд тавих хяналт нь хууль тогтоох дээд байгууллага болон бусад байгууллагаас гаргасан хууль, эрх зүйн актын хүрээнд хэрэгжих төрийн дээд хяналт юм. Гэвч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан зохицуулалт нь Цэц “дээд” хяналтаа хэрэгжүүлэх, маргааныг магадлан шийдвэрлэх эрхийг хязгаарласан буюу зөрчжээ. Учир нь Үндсэн хууль нь төрийн дээд хүчин чадал бүхий эрх зүйн акт бөгөөд бусад хууль тогтоомж түүнд нийцэж тохирсон байх ёстой. Үүнийг Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж баталгаажуулсан байдаг. Гэтэл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн өдрөөс хойш гарсан маргааныг хянан шийдвэрлэхээр хуульчилжээ.

Энэ нь Цэц 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө гарсан боловч Монгол Улсад үйлчилж, эрх бүхий албан тушаалтнаас хэрэглэж байгаа хууль, бусад шийдвэрийг хянахгүй үр дагаварт хүргэж байна.

2.Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн өдрөөс хойш гарсан маргааныг хянан шийдвэрлэхээр хуульчилсан тус заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу ... хянан шийдвэрлэнэ.” гэж заасныг зөрчсөн. Иргэд Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар өргөдөл, мэдээлэл гаргах эрхтэй. Гэвч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь иргэдийн өргөдөл, мэдээлэл гаргах эрхийг хязгаарлаж байна.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн”, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу ... хянан шийдвэрлэнэ.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн болохыг тогтоож, хүчингүй болгож өгнө үү.” гэсэн байна.

**Хоёр. Монгол Улсын иргэн Н.Ариунболд, Д.Оросоо нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ:**

“Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага байхаас гадна Монгол Улсад Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болдог билээ. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих энэхүү Үндсэн хуулийн цэцийн онцгой бүрэн эрх нь Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж, нийгмийн харилцааг зохицуулж байгаа аливаа хууль тогтоомж Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар гаргасан иргэний мэдээлэл, эрх бүхий этгээдийн хүсэлтийг хянан шийдвэрлэх замаар хэрэгждэг. 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Ардын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийг баталснаар 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 12 цагаас эхэлж Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг Монголын ард түмэн дагаж мөрдөж эхэлсэн.

Гэтэл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэц зөвхөн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомжийн маргааныг хянан шийдвэрлэнэ, үүнээс өмнө гарсан хууль тогтоомж/хууль, тогтоол, олон улсын гэрээ/-ийг хянан шийдвэрлэхгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасанд үл нийцэж байна. Учир нь Монгол Улсад хүчин төгөлдөр аливаа хууль тогтоомж нь Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа дээд хүчин чадалтай Үндсэн хуульд нийцсэн байх шаардлагыг Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасан.

Ардын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийг батлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хууль буюу БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай хуулийг мөн баталсан байдаг. Уг хуулийн Есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү Хавсралт хууль Монгол Улсын Үндсэн хуулийнхаа нэгэн адил хүчинтэй.” гэж зааж өгсөн.

Хавсралт хуулиар Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн бүх хуулийг мөнхүү Үндсэн хуульд



харшлахгүй бол цаашид хүчин төгөлдөр дагаж мөрдөх, Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн Үндсэн хуульд харшилсан хууль болон эрх зүйн бүх акт, тэдгээрийн заалтыг хүчингүй болсонд тооцох, хууль тогтоомжийг 1996 онд багтаан хийж дуусгах гэх мэт шилжилтийн үеийн харилцааг зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, 1996 онд багтаан хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллагууд хууль тогтоомжийг шинэчлэх, тодруулбал хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө гарсан хууль тогтоомж нь Үндсэн хуульд нийцсэн гэж үзвэл хэвээр үлдээх, гүйцэтгэх мэдлийн хүрээнд 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө гарсан хууль тогтоомж Үндсэн хуульд нийцсэн гэж үзвэл уг хуулийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг Хавсралт хууль олгосон.

Харин хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд Үндсэн хуульд нийцсэн гэж үзсэн боловч, шүүх эрх мэдэл буюу Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих бүрэн эрхийн хүрээнд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хууль тогтоомж Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцээс уг хууль тогтоомжид хяналт тавих бүрэн эрхийг маргаан бүхий хуулийн заалт хязгаарлаж байна гэж үзэн энэхүү мэдээллийг Үндсэн хуулийн цэцэд гаргаж байна.

Мэдээлэл гаргагчийн зүгээс 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлаас батлагдсан Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль Үндсэн хууль зөрчсөн талаар Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасан боловч Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 56 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу уг хууль Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг хянан шийдвэрлэх боломжгүй гэж үзэн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзжээ. Энэ нь Үндсэн хуулийн цэц 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө батлагдсан боловч одоо Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянах боломжгүй байгааг харуулж байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Жаран зургадугаар зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэж өгнө үү.” гэжээ.

***Гурав. Монгол Улсын иргэн Ц.Мөнгөнцацрал Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг гаргажээ:***



“Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хууль батлагдсанаас хойш 1988 онд батлагдсан Газрын хэвлийн тухай, 1991 онд батлагдсан Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай, Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай, Өмчлөлийн тухай зэрэг 8 хуулийг одоог болтол Монгол Улсын Их Хурлаас хүчингүй болсонд тооцоогүй, хүчин төгөлдөр үйлчилж төрийн захиргааны байгууллага шийдвэр, үйл ажиллагаандаа мөрдлөг болгосоор байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү Хавсралт хууль Монгол Улсын Үндсэн хуулийнхаа нэгэн адил хүчинтэй.” гэж, Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн бүх хуулийг мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй бол цаашид хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:” гээд 1 дэх заалтад “хууль ... Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;” гэж тусгасан. Үүнээс үзэхэд Үндсэн хууль батлагдахаас өмнө батлагдсан дээрх хуулиуд одоог болтол хүчин төгөлдөр үйлчилж Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гаргах маргааны зүйлд хамаарч байхад Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тхоюомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж хуульчилсан байх тул Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэхийг тогтоож, дүгнэлт гаргаж өгнө үү.” гэжээ.

***Дөрөв. Монгол Улсын иргэн Д.Цэрэнбадам Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг гаргажээ:***

“Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.”, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:” гээд 1 дэх заалтад “хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ ...” гэж, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заажээ.



Хууль тогтоогч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэсэн (цаашид “Батлагдсан цаг хугацааны хязгаарлалт” гэх) заалтыг оруулж, Үндсэн хуулийн хяналтыг батлагдсан цаг хугацаагаар хязгаарласан нь Үндсэн хуульд нийцэхгүй, зөрчсөн ердийн хууль, хуульчилсан акт нийгэмд хэрэгжих эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэн, Улсын Их Хурлын Тамгын газраас авсан мэдээллээр Монгол Улсын Үндсэн хууль батлагдахаас өмнө буюу 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс өмнө батлагдсан, хүчин төгөлдөр үйлчилж буй БНМАУ-ын Ардын Их Хурал болон БНМАУ-ын Бага Хурлаас баталсан 8 хууль, соёрхон баталсан буюу нэгдэн орсон 65 олон улсын гэрээ өнөөдрийг хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчилж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн агуулгаар эдгээр хуулиуд болон соёрхон баталсан буюу нэгдэн орсон олон улсын гэрээнүүд нь Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байх учиртай бөгөөд Үндсэн хуульд нийцсэн эсэхэд Үндсэн хуулийн цэц хяналт тавих бүрэн боломжтой байх ёстой. Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.” гэж заасан бөгөөд дээрх соёрхон баталсан буюу нэгдэн орсон олон улсын гэрээнүүдийн хувьд Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд Үндсэн хуулийн цэц хяналт хийх боломжийг хууль тогтоогч батлагдсан цаг хугацааны хориглолт хийснээрээ хязгаарласан байна.

Мөн Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн бүх хуулийг мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй бол цаашид хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.”, 3 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөнхүү Үндсэн хуульд харшилсан хууль болон эрх зүйн бүх акт, тэдгээрийн заалтыг хүчингүй болсонд тооцно.” гэж зааснаас үзвэл хууль тогтоогч ердийн хууль, соёрхон баталсан буюу нэгдэн орсон олон улсын гэрээг Үндсэн хуульд нийцүүлэх үүрэгтэй бөгөөд Үндсэн хуульд нийцсэн эсэхэд Үндсэн хуулийн цэц хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэгтэй байхаар байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж тунхаглан заасан ба энэхүү зарчим шаардлага нь хууль тогтоох эрх мэдэл бүхий байгууллагын ажиллах үеийн нөхцөл байдал, нийгмийн хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхлоос шалтгаалан түүний баталсан ердийн хуулийн хооронд зөрчил хийдлийг үүсгэсээр ирсэн нь Үндсэн хуулийн хяналтын байгууллага зайлшгүй орших шалтгаан нөхцөлийг бүрэлдүүлсэн байдаг. Энэхүү зөрчил, хийдлийг хууль

дээдлэх зарчим, шударга ёс, тэгш байдлын зарчимд нийцүүлэн өнөөгийн эрх зүйн системд олсон ололтоос ухраахгүй суурь зарчимдаа нийцүүлэн шийдвэрлэх нь Үндсэн хуулийн хяналтын байгууллага буюу Үндсэн хуулийн цэцийн үндсэн зорилго болно.

Өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж буй Үндсэн хуулийн агуулгаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, соёрхон баталсан буюу нэгдэн орсон олон улсын гэрээ нь Үндсэн хуульд бүрнээ нийцэх ёстой юм бол түүнийг нийцсэн эсэхийг хянах эрх Үндсэн хуулийн цэцэд олгогдсон байх нь зүй ёсны асуудал болно. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогч засаглалын салаа мөчрийн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоох, нийгмийн харилцааг зохицуулсан хэм хэмжээг хуулиар тодорхойлохдоо Үндсэн хуулийн агуулга зарчимд нийцүүлэхээс гадна Үндсэн хуульд хэрхэн нийцсэнийг хараат бус мэргэжлийн, дээд хяналт болох Үндсэн хуулийн цэц хяналт хийх боломж нөхцөлийг бүрдүүлсэн байх нь нэг талаар хууль тогтоогчид Үндсэн хуулиар оноосон үүрэг, нөгөө талаар Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрх юм.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэж өгнө үү.” гэсэн байна.

***Тав. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:***

“Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхтэй байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн болохыг дурдаад, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Цэцийн үйл ажиллагааны зарчим, арга хэлбэр, зохион байгуулалт, бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиар тодорхойлно.” гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн үзэл санааны үүднээс, түүнд тусгагдсан зохицуулалтын агуулга, зарчмын



хүрээнд шийдвэрээ гаргана. Энэ хүрээнд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж тусгагдсан.

Улсын Их Хурал хууль тогтоох, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хууль батлагдсаны дараа Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаас 1992 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гагцхүү хуулиар зохицуулж байхаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан харилцааг тэр тухай шинэ хууль батлан гаргах хүртэл хугацаанд уул харилцааг зохицуулж ирсэн хууль, эрх зүйн бусад актын заалтаар зохицуулна. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг Улсын Бага Хурлаас тогтоосон хуваарийн дагуу 1993 онд багтаан батлан гаргана.” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлыг 1996 онд багтаан хийж дуусгана.” гэж хуульчилсан. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурал өөрийн онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хуулийн суурь зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд нарийвчилсан зохицуулалт бүхий органик хууль батлан гаргах үүргийг хуулиар хүлээсэн байна.

Үндсэн хуулийн тулгуур зарчим, үзэл санааг гажуудуулахгүйгээр Үндсэн хуулийн заалтыг бусад хуулийн заалтаар баяжуулан хөгжүүлж, нийгмийн харилцааг нарийвчлан зохицуулснаар Үндсэн хууль өөрөө амьдрах чадвартай байж, нийгмийн харилцааг зохицуулах үүргээ гүйцэтгэдэг. Үндсэн хуульчилсан дээрх асуудлыг Улсын Их Хурал органик хууль буюу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тодруулан хуульчилсан нь Үндсэн хуулийн заалтад халдсан хэрэг бус харин Үндсэн хуулиар Улсын Их Хурлын бүрэн эрхэд онцгойлон хамааруулсан асуудлын эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэн тогтоосон гэж үзэж байна. Мэдээлэл гаргагчдын мэдээлэлд “... БНМАУ-ын Бага хурлаас 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай ... хуулийг ...” дурдсан байна. Тус агуулгын хүрээнд Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн, зөрчөөгүй эсэх талаар маргааныг хянан шийдвэрлэх нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлтэй харшилдах нөхцөл бүрдэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай шийдвэрийг хянаж дүгнэлт гаргах бөгөөд шаардлагатай бол дахин хянаж, эцэслэн шийдвэрлэдэг. Харин Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль нь

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиар олгосон гол үүргээс хэтэрсэн гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл Цэцийн гол үүрэг бол 1992 оны Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах маргааныг магадлан шийдвэрлэх чиг үүрэгтэй буюу Үндсэн хуулийн суурь зарчмыг л хамгаалах үүрэг хүлээнэ. Ердийн хуулиуд бол хууль дээдлэх зарчмын дагуу Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд нийцэн гарах ёстой ба Үндсэн хуулийг дэлгэрүүлж буй хэрэг гэж үздэг тул түүнээс өмнөх Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн, дэлгэрүүлж буй хуулиудыг Цэц шууд өнөөгийн Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянах боломжгүй юм.

Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээ, харьяалан шийдвэрлэх асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлээр тус тус зохицуулсан байна. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуульд дээд хяналт тавих субъект болохын хувьд түүний хяналтын цар хүрээг Үндсэн хуулиар тогтоодог учир тус маргааныг хянан шийдвэрлэх нь Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудалд хамаарахгүй тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, Жаран зургадугаар зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй гэж үзэж байна.” гэжээ.

***Зургаа. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээрх маргааныг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Дунд суудлын хуралдаанаар хянан хэлэлцэж, 01 дүгээр дүгнэлтийг гаргасан болно. Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:***

“1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” хэмээн хуульчилж Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг тодорхойлсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, үндсэн бүтцэд нийцүүлэн Үндсэн хуульд ёсыг хамгаалж, Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих бүрэн эрхтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн бүх хуулийг мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй бол цаашид хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “... Үндсэн хуульд харшилсан хууль болон эрх зүйн бүх акт, тэдгээрийн заалтыг хүчингүй болсонд тооцно.”, 4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийг



Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлыг 1996 онд багтаан хийж дуусгана.” гэж тус тус заасан боловч Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн “Мэдээлэл хүргүүлэх тухай” албан бичигт Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээс өмнөх хугацаанд баталж, өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа 9 хууль байгаа талаар дурджээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн дагуу Үндсэн хуульд нийцүүлэх арга хэмжээг хууль тогтоогчийн зүгээс аваагүй, эсхүл Үндсэн хуульд нийцсэн гэж үзэж хэвээр үлдээсэн хууль тогтоомж, түүний хэм хэмжээг Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх хууль зүйн боломжгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээг цаг хугацааны хүчин зүйлээр үндэслэлгүй хязгаарлаж, үндэсний эрх зүйн нэгдмэл орон зайг үгүйсгэсэн байна. Ийнхүү Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналтыг тавих бүрэн эрхийг хязгаарласан байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлд Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан, түүнийг хянан шийдвэрлэх нийтлэг журмыг, Далдугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тогтоосон байна. Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Жаран зургадугаар зүйлийн 4, Далдугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтад Үндсэн хуулийн цэцээс Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэх албан тушаалтныг нэрлэн заасан болохыг тэмдэглэх нь зүйтэй байна.” гэсэн байна.

### ***Дүгнэлтийн тогтоох хэсэгт:***

“1. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс

хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.”, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтад “хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно.”, Далдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй. ...” гэсэн болно.

***Долоо. Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг Улсын Их Хурал 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 30 дугаар тогтоолыг гаргасан байна. Үүнд:***

“1. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль

хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэжээ.

***Найм. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:***

“1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” хэмээн зааж, Үндсэн хуулийн цэцийн эрх зүйн үндэс, бүрэн эрхийг Үндсэн хуулиар тогтоосон билээ. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийн цэц нь Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхтэй байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн болохыг дурдаад, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Цэцийн үйл ажиллагааны зарчим, арга хэлбэр, зохион байгуулалт, бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиар тодорхойлно.” гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогч Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийг Үндсэн хуулийн үзэл санааны үүднээс, түүнд заасан зохицуулалтын агуулга, зарчмын хүрээнд шийдвэрээ гаргана гэж үзсэн бөгөөд энэ хүрээнд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж хуульчилсан.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаас 1992 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хууль /БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай/-ийн Тавдугаар зүйлийн 2 дахь





хэсэгт “Гагцхүү хуулиар зохицуулж байхаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан харилцааг тэр тухай шинэ хууль батлан гаргах хүртэл хугацаанд уул харилцааг зохицуулж ирсэн хууль, эрх зүйн бусад актын заалтаар зохицуулна. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг Улсын Бага Хурлаас тогтоосон хуваарийн дагуу 1993 онд багтаан батлан гаргана.” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлыг 1996 онд багтаан хийж дуусгана.” гэж хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурал онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хуулийн суурь зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд нарийвчилсан зохицуулалт бүхий органик хууль батлан гаргах үүргийг хуулиар хүлээсэн бөгөөд Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг шинэчлэн найруулах, хүчингүй болгох замаар Үндсэн хуулийн биелэлтийг хангах бүрэн боломжтой бөгөөд энэхүү үйл явц үргэлжилж байна. Үндсэн хуульчилсан дээрх асуудлыг Улсын Их Хурал органик хууль буюу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тодруулан хуульчилсан нь Үндсэн хуулийн заалтад халдсан хэрэг бус харин Үндсэн хуулиар Улсын Их Хурлын бүрэн эрхэд онцгойлон хамааруулсан асуудлын эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэн тогтоосон. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэц 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө батлагдсан хууль, бусад шийдвэрийг Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар маргаан хянан шийдвэрлэх нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд заасан Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудалтай харшилдах нөхцөл бүрдэж байгаа юм.

Үндсэн хуулийн цэцийн гол үүрэг бол 1992 оноос хойш батлагдсан Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж, Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг магадлан шийдвэрлэх, Үндсэн хуулийн суурь зарчмыг хамгаалах үүрэгтэй. Тодруулбал, 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиуд нь социализмын үзэл баримтлалыг эдийн засгийн болон улс төрийн чиг баримжаа болгож, нэг намыг улс төрийн тогтолцооны гол цөм болгож, түүний үзэл суртал, үйл хэргийг хамгаалан бэхжүүлж, ажилчин анги, түүний тэргүүний хэсэг нийгмийг удирдаж, хяналт тавьж, эрх зүйн хэм хэмжээ тогтоох үйл явц намын хяналтад байж, түүний бодлого, үзэл суртал, хөтөлбөр нь эрх зүйн үндсэн эх сурвалж болж байсан. 1992 оноос өмнө батлагдсан хууль тогтоомж нь дээрх Үндсэн хуулиудын суурь үзэл баримтлалд нийцэж, түүний тулгуур зарчмыг дэлгэрүүлэн батлагдсан эрх зүйн баримт бичиг бөгөөд тэдгээр хууль тогтоомж нь өнөөгийн хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгыг хамгаалан баталгаажуулсан, ардчилсан ёсны зарчимд суурилсан 1992 оны Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэх нь Үндсэн хуулийн цэц өөрөө Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 1, 2 дугаар зүйлийг тус тус зөрчих нөхцөл байдал үүсэхээр байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын

Үндсэн хуулийн цэц нь өнөөгийн Үндсэн хуулийн үзэл санааны үүднээс, түүнд тусгагдсан зохицуулалтын агуулга, зарчмын хүрээнд шийдвэрээ гаргах нь хууль ёсных юм. Үндсэн хууль бол төрийн суурь, эрх зүйн хамгийн дээд хүчин чадалтай баримт бичиг. Энэ ч үүднээс Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуульд дээд хяналт тавих субъект болохын хувьд түүний хяналтын цар хүрээг Үндсэн хуулиар тогтоодог. Иймд Үндсэн хуулийн цэц 1992 оноос өмнө батлагдсан хууль, бусад шийдвэрийн маргааныг хянан шийдвэрлэх нь түүний харьяалан шийдвэрлэх асуудалд хамаарахгүй.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчөөгүй гэж үзэж байна.” гэжээ.

***Ес. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд бэлтгэх хүрээнд дараах баримт бичиг, тайлбар, шийдвэртэй танилцаж, холбогдох эрх бүхий этгээдээс баримт, тайлбар, дүгнэлт гаргуулан авсан болно:***

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын 1992.01.13-ны өдрийн хуралдааны протокол, Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж XII, 2022;

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын 1991.11.06-ны өдрийн хуралдааны протокол, Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж III, 2022;

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангаас 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн УИХ-03/3197 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлбар;

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн 15/585 дугаар албан бичиг, түүний хавсралт болох Монгол Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл;

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр ирүүлсэн ТГ-02/1514 дугаар албан бичиг, хавсралтын хамт;

Монгол Улсын Гадаад харилцааны сайдын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн 09/4937 дугаар албан бичиг, хавсралтын хамт;

Монгол Улсын дээд шүүхийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 001/ХТ2024/0046 дугаар тогтоол;



Солонгосын Үндсэн хуулийн шүүх, Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн 20 жил, 2008 (Constitutional Court of Korea, Twenty Years of the Constitutional Court of Korea, 2008);

Венецийн комисс, Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан, судалгааны эмхэтгэл, 2022CDL-PI(2020) 004;

Г.Совд, “Далдугаар зүйл,” Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2000;

Холбогдох Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоол, албан бичиг, Үндсэн хуулийн цэцийн магадлал, дүгнэлт, тогтоол;

Холбогдох ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл, илтгэл, өгүүлэл, судалгааны материал зэрэг.

## **ҮНДЭСЛЭЛ:**

Монгол Улсын Их Хурал (цаашид “Улсын Их Хурал” гэх)-аас 1997 онд баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заажээ. Энэ зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэсэн 01 дүгээр дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (цаашид “Үндсэн хуулийн цэц” гэх)-ийн дунд суудлын хуралдаанаас 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр гаргажээ. Тус дүгнэлтийг Улсын Их Хурал мөн оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж 30 дугаар тогтоолыг гаргасан байна.

### **1.Үндсэн хуульт ёс: онол, Монголын жишээ**

1.1.Үндсэн хуульт ёс нь ардчилсан Үндсэн хуулийн мөн чанар бөгөөд дэлхий нийтийн зарчим болж хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтод тооцогдсон байдаг. Тухайлбал, төрийн эрх мэдлийг Үндсэн хуулиар хязгаарлах нь хүний үндсэн эрх, эрх чөлөө болон түүнтэй адилтгах эрх (нийтэд нь “үндсэн эрх” гэх)-ийг хамгаалах урьдач нөхцөл болж, төрийн байгууллага, албан тушаалтан энэ хязгаар дотор өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлж, хуулийн өмнө хариуцлага хүлээнэ. Үндсэн хуулийн эрх зүйн онол, нийтлэг чиг хандлагаар үндсэн хуульт ёс нь Үндсэн хуулийн агуулга, эрх мэдлийн уг сурвалж, хэм хэмжээний эрэмбэ, хэрэгжүүлэх баталгаа гэсэн дөрвөн шинжээр тодорхойлогдоно:

1.1.1.Үндсэн хуулиар тухайн нийгмийнхээ хэв журам, тогтвортой байдлыг хангах үүднээс төрийн эрх мэдлийн ерөнхий бүтцийг тогтоогоод зогсохгүй үндсэн эрхийг хамгаалах, төрийн эрх мэдлийг хуваарилах зэрэг суурь зарчмыг тусгаж хэрэгжүүлэх нь үндсэн хуульт ёсны агуулгын шаардлага болно.

Төрийн байгууллага, албан тушаалтан үндсэн эрхийг хүндэтгэх үүрэгтэй. Туйлын эрхээс бусад үндсэн эрхийг хязгаарлах тохиолдолд уул хязгаарлалт нь хуульд тодорхой заагдсан, тохирсон, шүүхийн хяналтад байх зэрэг нөхцөлийг хангахыг Үндсэн хуулиар шаарддаг тул эдгээр нөхцөлийн аль нэгийг хангаагүй бол тухайн хязгаарлалт үндсэн эрхийг зөрчсөн гэх үндэслэл болно. (Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлт) Төрийн эрх мэдэлд Үндсэн хуулиар тавьсан хязгаарлалтын хэрэгжилтийг хянах механизм бүрдүүлэхгүй бол үндсэн эрх хоосон амлалт болно. Иймд төрийн хийх ёстой ажлыг чиг үүргээр нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван эрх мэдэлд хуваарилж, эдгээрийн хоорондын хяналт, тэнцлийг хангах замаар иргэн бүр үндсэн эрхээ баталгаатай эдлэх нөхцөлийг бүрдүүлдэг байна.

1.1.2. Үндсэн хууль нь үндсэн эрх, төрийн эрх мэдлийн хуваарилалт зэрэг суурь эрхэмж (үнэт зүйл)-ийг хамгаалдаг учраас түүнийг батлах эрх мэдэл нь ердийн хууль тогтоох эрх мэдлээс өндөр түвшинд хамаарах бөгөөд эдгээр хоёр эрх мэдэл нь уг сурвалжийн хувьд ялгаатай. Үндсэн хуулийг баталж, улс төрийн шинэ дэглэмийг буюу үндсэн хууль байгууллыг тогтоох анхдагч эрх мэдэл нь ард түмний эрх мэдэл (constituent power буюу бүрэлдүүлэх эрх мэдэл) байдаг бол ийнхүү тогтоосон дэглэм дотор өдөр тутам хэрэгжүүлдэг үүсмэл эрх мэдэл нь ердийн эрх мэдэл (constituted power буюу бүрэлдүүлсэн эрх мэдэл)-д хамаарна.

Орчин үеийн үндсэн хууль ёсны дагуу Үндсэн хууль нь ард түмнээс эхтэй. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ч тэрхүү нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийг баталсантай адил легитим шинжийг хангасан тусгай журмаар хэлэлцэж батлахаас гадна Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцсэн байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль батлах болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам нь ардчилсан нийгмийн хамгийн суурь асуудлыг шийддэг учраас ердийн хууль батлах журмаас илүү өндөр шаардлага (өргөн бүрэлдэхүүнээр эсхүл олон үе шат, иргэдийн оролцоо, мэргэжлийн судалгаа, улс төрийн зөвшилцөлтэйгөөр ил тодоор хэлэлцэж илүү өндөр босгоор батлах зэрэг) хангах ёстой. Түүнчлэн ердийн эрх мэдлийг хэрэгжүүлж нийтээр дагаж мөрдөх хуулийг боловсруулах, батлах, биелэлтэд нь хяналт тавихад иргэдийг оролцуулах, тэдгээрийн өмнө хариуцлага хүлээдэг байх шаардлагатай. Энэ утгаараа үндсэн хууль ёс нь ардчилсан ёсыг бэхжүүлдэг байна.

1.1.3. Үндсэн хууль нь эрэмбийн хувьд тухайн улсын дотор үйлчилдэг хамгийн дээд хууль юм. Дээд хууль нь шинэ дэглэм тогтоох ард түмний эрх мэдлийг илэрхийлж, тэдгээрийн илүү дээд хүсэл зоригийг агуулдаг бол ердийн хууль нь парламентын болон сонгогчдын ердийн эрх мэдлийг илэрхийлж, тэдний тухайн цаг үеийн хүсэл зоригийг агуулдаг. Тэрхүү дээд хууль нь дээд хүчин чадалтай, заавал биелэх шинжтэй тулгуур хууль тул ердийн эрх мэдлийг хязгаарлаж, чиглүүлнэ. Иймээс хууль болон

эрх зүйн акт нь Үндсэн хуульд нийцэж байхыг үндсэн хуульт ёс шаардана. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн алинаас нь ч гаргасан эрх зүйн акт Үндсэн хуулийг зөрчих ёсгүй.

Төрийн эрх мэдэл нь гагцхүү Үндсэн хуулиар тогтоосон хязгаарын дотор хэрэгжиж байгаа тохиолдолд хууль ёсных байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль нь төрөөс дээгүүр оршдог тул төрийн бүх байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа Үндсэн хуульд захирагдана. Иймээс хууль, бусад шийдвэр нь Үндсэн хуульд нийцсэн тохиолдолд л хүчин төгөлдөр гэж үзнэ.

1.1.4. Үндсэн хуулийг тунхаглал төдий болгохгүйн тулд түүнийг чандлан сахиулах баталгааг бүрдүүлэх нь зүй ёсны хэрэг. Тодруулбал, үндсэн хуульт ёс нь Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг хязгаарлах, хувь хүний үндсэн эрхийг хүндэтгэх болон төрийн эрх мэдлийг хуваарилах байдалд хяналт тавьж, баталгаажуулах механизмыг шаардана. Үндсэн хууль нь эрх зүйн тогтолцооны хамгийн дээд хууль болохын хувьд хууль, эрх зүйн акт түүнд нийцсэн байх ёстой учраас үүний хэрэгжилтэд шүүхийн журмаар тавьдаг хяналтыг үндсэн хуулийн хяналт гэж нэрлэдэг. Энэ хяналт нь хууль, бусад шийдвэр Үндсэн хуультай зөрчилдөж буй эсэхийг хянан шийдвэрлэж, Үндсэн хуулийг зөрчсөн бол тухайн хууль, шийдвэрийг хүчингүй болгох, эсхүл хэрэглэхгүй байх шүүхийн эрх мэдэл юм.

Үндсэн хуулийн шүүх нь төрийн аль ч эрх мэдэлд хамаарах бүхий л байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцсэн эсэхэд хяналт тавих чиг үүрэгтэй. Энэ ч утгаараа “Үндсэн хуулийн шүүхийн гол үүрэг бол Үндсэн хуультай зөрчилдөж буй хуулийн заалтыг олж тогтоох, эдгээр заалтыг эрх зүйн тогтолцооноос хасах явдал юм.” (Венецийн комисс, 2020, х. 160) Үндсэн хуульт ёс нь Үндсэн хуулийг төрийн эрх мэдлээс, түүний дотор хууль тогтоох эрх мэдлээс дээгүүрт тооцох, тэдгээрийг Үндсэн хуулиар хязгаарлах гэсэн утгатай учраас Үндсэн хуулийн биелэлтийг Үндсэн хуулийн шүүхийн журмаар хянах боломж олгож нийгмийг ард түмний тулгуур хуулийн хүрээнд нэгтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2. Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль (цаашид “Үндсэн хууль” гэх)-ийг боловсруулж батлахдаа эрх зүйт төрийг бий болгохыг зорьсон. Энэ зарчмыг Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хууль дээдлэх ёс гэж нэр томъёогоор тусгасан байна. Хууль дээдлэх ёс нь эрх зүйн байдлыг дордуулсан Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглох, аливаа хууль эрх зүйн тодорхой байдлыг хангах, үндсэн эрхийн хязгаарлалт хууль ёсны зорилгодоо тохирсон байх, хараат бус, шударга шүүхийн хяналтад байх зэрэг зарчмыг төдийгүй хүний үндсэн эрхийг баталгаатай хангах, төрийн эрх мэдэл хуваарилах, аливаа хууль, эрх зүйн акт Үндсэн хуульд нийцсэн байх зэрэг үндсэн хуульт ёсны шаардлагыг багтаасан өргөн агуулгатай. Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль нь Монгол Улсын дээд хууль болж, төр нь

Үндсэн хуулийг дагаж мөрдөж буй хэрээр эрх зүйт төрийн шинжийг илтгэх бөгөөд Үндсэн хуулиа дээдэлж байвал тэр нь үндсэн хуульт төр мөн.

Үндсэн хуульт ёс бол Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олсон, түүний салшгүй хэсэг болно. Үндсэн хуулийн цэцээс маргаан хянан шийдвэрлэхдээ уг зарчмыг удаа дараа хэрэглэсэн байна. (Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10, 12, 15, 2019 оны 02, 2020 оны 01, 06 дугаар дүгнэлт) Тухайлбал, Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 15 дугаар дүгнэлтээр “Монгол Улсын Үндсэн хуулиар ардчилсан эрх зүйт төрийн зарчмыг үндэс болгон тогтоож, хүний болон иргэний эрх, эрх чөлөөний баталгаа, үндсэн хуульт ёсыг баталгаажуулан, төрийн эрх мэдлийн хуваарилалтыг тодорхойлсон. Хууль тогтоогчоос батлан гаргасан хууль тогтоомжийн биелэлтийг хангах, түүнийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, бусад нийтийн захиргааны байгууллагын аливаа шийдвэр үйл ажиллагаа дээр дурдсан Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд үндэслэсэн байхын зэрэгцээ, иргэний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн байх учиргүй” гэж тайлбарласан. Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 06 дугаар дүгнэлтээр Үндсэн хуулийн түвшинд эрх хэмжээг нь тусгайлан заасан институтын үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, үндсэн хуульт ёсыг хангахад чиглэгдэнэ гэж үзсэн байна.

1.2.1. Монгол Улсын Үндсэн хууль хүний үндсэн эрхийг хамгаалж, үүний тулд төрийн эрх мэдлийг хуваарилж уул эрх мэдэлд хязгаарлалт тогтоосон. Тодруулбал, нэг талаас Үндсэн хуульд хүн бүрийг адилхан хүн гэж хүлээн зөвшөөрч хүний нэр төрийг нь хүндэтгэхийг төрд үүрэгжүүлж, хүн хувьдаа эдлэх үндсэн эрхийг цогцоор нь баталгаажуулж, нөгөө талаас Үндсэн хуулиар парламентын засгийг сонгож төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд хуваарилж, харилцан хяналт, тэнцлийг хангасан байна.

1.2.2. Үндсэн хуулийг батлах бүрэн эрх бүхий Бүгд Найрамдах Монгол Ард Улс (цаашид “БНМАУ” гэх)-ын Ардын Их Хурлыг 1990 оны анхны ардчилсан сонгуулиар бүрдүүлсэн. Үндсэн хуулийн төслийг боловсруулж хэлэлцэж батлахад нэг жил хагасын хугацаа зарцуулж, иргэдийн оролцоо, улс төрийн зөвшилцөл, мэргэжлийн санал, дүгнэлтийг хэд хэдэн үе шатаар тусгасан учраас БНМАУ-ын Ардын Их Хурал (цаашид “Ардын Их Хурал” гэх) нь ард түмний эрх мэдлийг хэрэгжүүлсэн гэж үзнэ. Үндсэн хуулийн оршилд “Монголын ард түмэн бид: ... -эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.” гэж бичсэнээс энэ агуулга харагдана. Үндсэн хуулиар ердийн эрх мэдлийг хэн ямар хүрээнд хэрэгжүүлэхийг тогтоосон: хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд, гүйцэтгэх эрх мэдлийг Засгийн газар болон түүний харьяа байгууллагад хадгалуулсан бол шүүх эрх мэдлийг гагцхүү

шүүх хэрэгжүүлэх зэргээр зааж, үндсэн эрхийг дээдлэхийг төрийн бүх байгууллага, албан тушаалтанд үүрэгжүүлсэн.

1.2.3.Хууль, эрх зүйн бүх акт Үндсэн хуульд нийцсэн байхын ач холбогдлыг Үндсэн хуулийн төслийг хэлэлцэж байх үед онцолж байжээ. Жишээ нь БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн чуулганы хуралдаанаар “гол зарчим бол Үндсэн хуультай харшилсан ямар ч хуулийг баримтлахгүй гэсэн зарчим байгаа. Энэ бол тулгуур ойлголт.” гэжээ. (Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж III, 2022, х. 366) Тиймээс Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасан. Хууль, бусад шийдвэр, үйл ажиллагаа энэ заалтыг зөрчсөн гэсэн олон шийдвэрийг Үндсэн хуулийн цэц гаргасан. (Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 03, 2002 оны 03, 2007 оны 02, 08, 2010 оны 02, 04, 2018 оны 10, 2019 оны 02, 2020 оны 01, 12, 2021 оны 02 дугаар дүгнэлт, 2000 оны 02, 2002 оны 03, 2007 оны 02, 2010 оны 02, 2018 оны 03, 2019 оны 03, 2021 оны 01, 2022 оны 02 дугаар тогтоол зэрэг) Жишээлбэл Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 03 дугаар дүгнэлтээр “Аливаа хууль Үндсэн хуульд харшлахгүй байх нь Үндсэн хуулийн чухал шаардлага, зарчим” болохыг тэмдэглэсэн байна.

1.2.4.Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж тодорхойлсон бол Жаран зургадугаар зүйлд Үндсэн хуулийн цэц хууль, бусад шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэх, албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх эсхүл түүнийг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх маргаантай асуудлыг хянан шийдвэрлэхээр зохицуулсан байна. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 01 дүгээр дүгнэлтээр “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, үндсэн бүтцэд нийцүүлэн Үндсэн хууль ёсыг хамгаалж, Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих бүрэн эрхтэй.” болохыг онцлон дурджээ.

Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй аль ч байгууллага, албан тушаалтан Үндсэн хуулийг зөрчих ёсгүй тул Үндсэн хуулийн цэц тэдгээрийн шийдвэр, үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцсэн эсэх маргааныг өөрийн бүрэн эрхийн хүрээнд хянан шийдвэрлэж, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болдог. Иймээс 1992 оны Үндсэн хууль нь Үндсэн хуулиа дээдэлж шүүхийн хяналт, хамгаалалтад авсан учраас түүний хэв маяг ардчилсан Үндсэн хууль болохыг харуулна.

## **2.Үндсэн хуулийн цэцийн хяналтын хүрээ**



2.1. Үндсэн хуульд нийцсэн байх зарчим нь эрх зүйн бүх актад үйлчилнэ. Тухайн актыг ямар байгууллага, албан тушаалтан гаргасан эсхүл хэм хэмжээ нь ямар төрөлд хамаарахаас үл хамаарч Үндсэн хуульд бүрнээ нийцэх учиртай. Үндсэн хууль бол хууль зүйн хамгийн дээд хүчин чадалтай учраас түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгслийн хувьд нэгдмэл, цогц, бусад бүх эрх зүйн хэм хэмжээнээс дээгүүр байна.

2.2. Үндсэн хуульд нийцсэн байх зарчим нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цаг хугацаа, орон зайгаар хязгаарлагдахгүй үйлчилнэ. Хууль, бусад шийдвэр нь хүчин төгөлдөр үйлчилж буй тохиолдолд Үндсэн хуулийг дагаж мөрдөхөөс өмнө эсхүл дараа батлагдсан эсэхээс үл хамааран Үндсэн хуульд нийцсэн байх ёстой бөгөөд үүний баталгааг хангахын тулд үндсэн хуулийн хяналт хэрэгжих шаардлагатай. Үндсэн хуульд нийцээгүй хууль, бусад шийдвэр байх ёсгүй тул тэдгээрийг Үндсэн хуульд нийцсэн эсэхийг шүүхийн журмаар тогтоох, нийцээгүй хэм хэмжээг хүчингүй болгох боломжийг хаах ёсгүй.

2.3. Улсын Их Хурлаас 1997 онд баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх хүрээг цаг хугацааны хүчин зүйлээр хязгаарласан байна. Ийнхүү хязгаарласнаар Үндсэн хуулийн цэц 1992 оны Үндсэн хуулийг дагаж мөрдөхөөс өмнө батлагдсан хууль, эрх зүйн актыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх боломжгүй болжээ. Тухайлбал, 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө гарсан хууль тогтоомж Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлаар маргаан үүсгэхээс удаа дараа татгалзахад дээрх хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг удирдлага болгожээ. (Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 52, 2007 оны 97, 2015 оны 125, 2019 оны 55, 56, 57 дугаартай гишүүний тогтоол, 2015 оны 3/490 дугаартай албан бичиг, 2019 оны 19, 20 дугаартай магадлал зэрэг)

2.4. Улсын Их Хурлын Тамгын газраас 2024 онд ирүүлсэн ТГ-02/1514 дугаар албан бичгийн Хавсралт 1-д зааснаар Үндсэн хуулийг бүх нийтээр дагаж мөрдсөн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө батлагдсан 9 хууль өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд 1990 оноос 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдөр хүртэл БНМАУ-ын Бага Хурлын 119 тогтоол батлагдсан байна. Түүнчлэн Монгол Улсын Гадаад харилцааны сайдын 2024 оны 09/4937 дугаар албан бичгээр ирүүлсэн жагсаалтад бичсэнээр 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө Монгол Улсын соёрхон баталсан буюу нэгдэн орсон 106 олон улсын олон талт гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна. Иймд эдгээр 9 хууль, 119 тогтоол нь Монгол Улсын хууль тогтоомж, 106 гэрээ нь Монгол Улсын олон





улсын гэрээ мөн байхад тэдгээр нь Үндсэн хуульд нийцсэн эсэхийг үндсэн хуулийн хяналтын журмаар тогтоох боломжгүй нөхцөл үүссэн байна.

2.5. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 01 дүгээр дүгнэлтэд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь “Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээг цаг хугацааны хүчин зүйлээр үндэслэлгүй хязгаарлаж, үндэсний эрх зүйн нэгдмэл орон зайг үгүйсгэсэн” гэж үзсэн нь үндэслэлтэй байна. Учир нь 1992 оны Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө гарсан хууль тогтоомж болон харьяаллын хүрээнд хамаарах маргаан бүхий бусад асуудлыг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхгүй тохиолдолд Үндсэн хуульд нийцээгүй хууль, бусад шийдвэр хүчин төгөлдөр үйлчлэх боломжтой. Өөрөөр хэлбэл, 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө гарсан хууль, бусад шийдвэр нь 1992 оны Үндсэн хуулийн хяналтын гадуур үлдэж, тусдаа дэг журам үүсгэхээр байна. Үүний үр дүнд 1992 оны Үндсэн хуулийн дэг журам болон түүнээс гадуурх дэг журам бий болж, Монгол Улсын үндэсний эрх зүйн нэгдмэл орон зай эвдэгдэнэ. Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.” гэж заасан нь Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдах (Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Тавин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг)-ыг хэлэхээс гадна Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилж буй бүхий л хууль, шийдвэр, үйл ажиллагаа нэг Үндсэн хууль (дээд хууль буюу 1992 оны Үндсэн хууль)-д бүрнээ нийцэх утгатай.

2.6. Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилж буй аливаа хууль, бусад шийдвэр хэзээ батлагдсан бэ гэдгээс үл хамааран Үндсэн хуульд нийцэх, үүний биелэлтэд Үндсэн хуулийн цэц бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавих нь Үндсэн хуулийн үзэл баримтлал юм. Үндсэн хуулийн Жаран дөрөв, Жаран зургадугаар зүйлийн дагуу Үндсэн хуулийн цэц нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах хууль, бусад шийдвэр хэзээ батлагдсанаас үл хамааран Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэхээр байна.

1992 оны Үндсэн хуулийн төслийг хэлэлцэж байх үед аливаа хууль, шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудал нь үндсэн хуулийн хяналтад байна гэж үзсэн. Тухайлбал, БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн чуулганы хуралдаанаар “Үндсэн хуультай харшилсан ямар ч хуулийг баримтлахгүй гэсэн зарчим ... маргаан гарах учраас Үндсэн хуулийн шүүх ажилламаар байгаа юм.” гэж тэмдэглэсэн байна. (Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж III, 2022, х. 366) Түүнчлэн Ардын Их Хурлын 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар “Үндсэн хуулийн цэцийг шинэ Үндсэн хуулийн дагуу нэн даруй байгуулан ажиллуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. ... Эрх зүйн салбарт хийх шинэчлэлийн чухал салбар нь Үндсэн хууль, Монгол Улсын олон



улсын гэрээнд нийцэж байгаа эсэхийг хянан тодорхойлж, шаардлагатай арга хэмжээ авах явдал юм.” гэж онцолжээ. (Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж XII, 2022, х. 646)

Үндсэн хуулийн төслийг хэлэлцэж Ардын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Бага Хурал 1992 оны 5 дугаар сарын 08-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг батлахдаа Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэхийг Үндсэн хуулийн цэцэд хориглоогүй байжээ. Иймээс Үндсэн хуулийн цэц энэ төрлийн маргааныг харьяалан шийдвэрлэх бүрэн эрхтэй байсан бөгөөд энэ нь олон улсын сайн туршлагад нийцнэ.

2.7. Үндсэн хуулийн процессын эрх зүйн дагнасан судалгаанаас үзэхэд Үндсэн хуулийг батлахаас өмнөх үеийн хууль, эрх зүйн акт Үндсэн хуульд нийцсэн эсэхийг Үндсэн хуулийн шүүхээс хянах нь ардчилсан, эрх зүйт төртэй улсуудын хувьд сайн туршлагад тооцогддог. Тухайлбал, Бүгд Найрамдах Солонгос Улсын хувьд Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөхөөс өмнөх хууль тогтоомж Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянаж хэд хэдэн шийдвэр гаргасан байна. (Солонгосын Үндсэн хуулийн шүүх, 2008, х. 214, 340, 347, 349)

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид “ХБНГУ” гэх)-ын Үндсэн хуулийг дагаж мөрдөхөөс өмнө батлагдсан эрх зүйн акт Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг хийсвэр болон тодорхой хяналтын журмаар илүү өргөн хүрээнд хянах боломжтой. Нэг талаас, ХБНГУ-д Холбооны болон аль нэг муж улсын Засгийн газар эсхүл Бундестагийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь Холбооны Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт гаргаж хандсанаар хэм хэмжээний хийсвэр хяналт хэрэгждэг. Энэ хүрээнд ХБНГУ-д Үндсэн хууль батлагдахаас өмнө гарсан эрх зүйн акт тухайн Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг хийсвэр хяналтын журмаар шийдвэрлэх бололцоотой байна гэжээ. Нөгөө талаас, аль ч шатны шүүх нь хэрэглэж буй хуулиа Үндсэн хуульд нийцсэн эсэхэд эргэлзвэл тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Үндсэн хуулийн шүүхэд хандаж энэ эргэлзээгээ шийдвэрлүүлэх боломжтой бөгөөд үүнийг хэм хэмжээний тодорхой хяналт гэж нэрлэдэг. Гэтэл ХБНГУ-д Үндсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө гарсан хууль, эрх зүйн актыг Үндсэн хуульд нийцсэн эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхийг ердийн шүүхэд өгсөн ажээ. Тодруулбал, Үндсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө гарсан хууль болон эрх зүйн бусад акт Үндсэн хуульд нийцсэн эсэхийг тодорхой хяналтын хүрээнд ердийн шүүх өөрөө хянах бүрэн эрхтэй бөгөөд Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл шийдвэр гаргахдаа тухайн актыг хэрэглэхгүй байх боломжтой гэж холбогдох бүтээлд тусгасан байна.

Монгол Улсын нэгэн адил эрх зүйн социалист бүлд хамаарч байсан бусад улсад Үндсэн хуулийн шүүх нь шинээр батлагдсан Үндсэн хуультайгаа нэгэн зэрэг үүссэн ч Үндсэн хууль нь хүчин төгөлдөр болохоос өмнө гарсан хууль болон эрх зүйн бусад акт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэдэг. Тухайлбал, хуучин эрх зүйн актыг хянахгүй байх нь өмнөх үеийнхээ эрх зүйг хяналтаас гадуур үлдээнэ гэсэн үг учраас эдгээр улсын Үндсэн хуулийн шүүхийн ихэнх нь Үндсэн хууль батлагдахаас өмнө гарсан актыг ч мөн ялгаагүй хянадаг болохыг судлаачид тэмдэглэсэн байна.

### **3. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн өмнөх жишиг**

3.1. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль батлагдах хүртэл буюу 1992 оноос 1997 оны 5 дугаар сарын 01-ний өдөр хүртэл Үндсэн хуулийн цэц Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө гарсан ч хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, бусад шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэх хоёр маргааныг харьяалан шийдвэрлэжээ.

3.2. Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 02 дугаар дүгнэлтээр “БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар батлагдсан “хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрмийн” 5, 6, 12 дугаар зүйлд тусгагдсан хөндлөнгийн шүүхтэй холбоотой заалтууд, мөн дүрмийн 9 дүгээр зүйлийн ажил хаяхыг хориглосон субъектүүдийг Монгол Улс нэгдэн орсон Олон улсын гэрээ, хэлэлцээрээс хэт өргөтгөсөн, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд /хуучин нэрээр/ хөдөлмөрийн хамтын маргааныг шийдвэрлэх эрх хэмжээ олгосон заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2, 3, 47 дугаар зүйлтэй харшилж байгаа тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралтын хуулийн 5 дугаар зүйлийн 3-т зааснаар хүчингүй болох ёстой байжээ. Харин эдгээр заалтуудыг холбогдох эрх бүхий байгууллагууд үйл ажиллагаандаа одоо болтол хэрэглэж, удирдлага болгосоор байгааг харгалзан Монгол Улсын Их Хурал Үндсэн хууль зөрчсөн дээрх заалтуудыг тухайлан хүчингүй болгох нь зүйтэй гэсэн дүгнэлтийг оруулж байна.” гэжээ. Улсын Их Хурлын 1993 оны 33 дугаар тогтоолоор энэхүү дүгнэлтийг хүлээж авах боломжгүй гэж үзсэн тул Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаар “Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм”-ийн 5, 6, 12 дугаар зүйлийн хөндлөнгийн шүүхтэй холбоотой заалтууд, 9 дүгээр зүйлийн “Батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий ... байгууллагад ажил хаяхыг хориглоно” гэснээс бусад хэсгийг Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Дөчин долдугаар зүйлтэй нийцэхгүй байна гэж үзээд тус тус хүчингүй болгожээ. (Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 03 дугаар тогтоол)

3.3. БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 169 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Үйлдвэрийн

газрын хувьчлах эд хөрөнгийн үнэлгээний журам”-ын 4 дүгээр бүлгийн 12 дахь хэсгийн “... БНМАУ-ын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын шийдвэр эцсийн болно”, мөн тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулах нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 17 дахь хэсгийн “... БНМАУ-ын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын шийдвэр эцсийн болно” гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх заалтад “иргэн Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй ...”, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн 1994 оны 08 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцээс Улсын Их Хуралд оруулжээ. Улсын Их Хурлын 1994 оны 89 дүгээр тогтоолоор энэхүү дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн байна.

3.4. Улсын Их Хурлаас 1997 оны 5 дугаар сарын 01-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг баталснаас хойш ч Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг цаг хугацаагаар хязгаарлаагүй жишиг байжээ. Тодруулбал, Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар дүгнэлтээр БНМАУ-ын Бага Хурлаас 1991 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр буюу Үндсэн хуулийг дагаж мөрдөхөөс өмнө баталсан Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэж байсан бөгөөд Улсын Их Хурлын 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 82 дугаар тогтоолоор энэхүү дүгнэлтийг хүлээн зөвшөөрчээ.

3.5. Дээрх гурван маргааныг хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээс үзэхэд 1992 оны Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчлэхээс өмнө гарсан хууль, бусад шийдвэр нь уг Үндсэн хуульд нийцээгүй байхыг үгүйсгэх аргагүй байна. Иймд Үндсэн хуулийн цэц ардчилсан Үндсэн хуулийг дагаж мөрдөхөөс өмнө батлагдсан ч хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, бусад шийдвэрийг тухайн Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянан шийдвэрлэх үндэслэлтэй байна.

#### **4. Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хууль ба Үндсэн хуулийн цэцийн хяналт**

4.1. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийг дагаж мөрдөхөөс өмнө БНМАУ-ын хэмжээнд үйлчилж байсан хууль болон эрх зүйн бусад актын бүхэл бүтэн тогтолцоо байсан бөгөөд эдгээр актыг нэг өдөр, цагт бүгдийг хүчингүй болговол нийгмийн амьдрал эрх зүйн зохицуулалтгүй болох аюултай байсан гэж тухайн үед үзэж байжээ. (Г.Совд, 2000, х. 270) Иймээс

тэдгээр хуучин актыг Үндсэн хуульд нийцүүлэн шинэчлэх шаардлага зүй ёсоор үүссэн. Өөрөөр хэлбэл, шинэ Үндсэн хуулийг дагаж мөрдсөн үеэс эхлээд түүнд харшилсан хуучин актыг хүчингүй болгох, түүнд харшлахгүй бол цаашид хүчин төгөлдөр дагаж мөрдөх хэрэгтэй болсон тул Ардын Их Хурлаас 1992 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хууль (цаашид “Хавсралт хууль” гэх)-ийг баталжээ.

4.2.Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гагцхүү хуулиар зохицуулж байхаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан харилцааг тэр тухай шинэ хууль батлан гаргах хүртэл хугацаанд уул харилцааг зохицуулж ирсэн хууль, эрх зүйн бусад актын заалтаар зохицуулна. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг Улсын Бага Хурлаас тогтоосон хуваарийн дагуу 1993 онд багтаан батлан гаргана.”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлыг 1996 онд багтаан хийж дуусгана.” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарт Хавсралт хуулийн дээрх хоёр заалтыг дурдаж, “... Улсын Их Хурал онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хуулийн суурь зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд нарийвчилсан зохицуулалт бүхий органик хууль батлан гаргах үүргийг хуулиар хүлээсэн бөгөөд Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг шинэчлэн найруулах, хүчингүй болгох замаар Үндсэн хуулийн биелэлтийг хангах бүрэн боломжтой бөгөөд энэхүү үйл явц үргэлжилж байна. Үндсэн хуульчилсан дээрх асуудлыг Улсын Их Хурал органик хууль буюу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тодруулан хуульчилсан нь Үндсэн хуулийн заалтад халдсан хэрэг бус харин Үндсэн хуулиар Улсын Их Хурлын бүрэн эрхэд онцгойлон хамааруулсан асуудлын эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэн тогтоосон.” гэсэн нь үндэслэлгүй байна.

4.3.Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийн дагуу Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан хуулийг 1993 онд багтаан батлан гаргах, хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлыг 1996 онд багтаан хийж дуусгах үүрэг хүлээсэн байна. Улсын Их Хурлын энэ үүрэг нь тэдгээр хууль тогтоомж Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг Үндсэн хуулийн цэцээс хянан шийдвэрлэхэд саад болохгүй. Тодруулбал, Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хууль, бусад шийдвэр, үйл ажиллагаа Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байх бөгөөд эдгээрээс Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн Жаран дөрөв, Жаран зургадугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хамаарах

асуудлаар маргаан үүсгэх, хянан шийдвэрлэхээр тодорхой зохицуулсан. Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн ерөнхий зохицуулалтыг хэрэглэхдээ тухайн дагаж мөрдөх гэж буй хуулийн илэрхий заалтыг шууд үгүйсгэж болохгүй. Иймд Хавсралт хуульд хууль тогтоогчийн үүргийг тусгайлан заасан нь Үндсэн хуулийг дагаж мөрдөхөөс өмнө гарсан бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, бусад шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэх маргааныг хянан шийдвэрлэх талаарх Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг үгүйсгэх үндэслэл болохгүй.

4.4. Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу аливаа хүчин төгөлдөр хууль, олон улсын гэрээ, эрх зүйн акт Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байна. Энэ зарчмыг хангах үүднээс Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн хууль, олон улсын гэрээг мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй гэж үзвэл дагаж мөрдөх үүргийг төрийн бүх байгууллага, албан тушаалтан хүлээх, харин харшилбал хүчингүйд тооцох буюу Үндсэн хуульд нийцүүлэх нарийвчилсан зохицуулалтыг Хавсралт хуульд тусгасан.

Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн бүх хуулийг мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй бол цаашид хүчин төгөлдөр дагаж мөрдөх, харин Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөнхүү Үндсэн хуульд харшилсан хууль болон эрх зүйн бүх акт, тэдгээрийн заалтыг хүчингүй болсонд тооцохоор тус тус заажээ. (Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг) Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн хууль Үндсэн хуульд харшилсан бол Улсын Их Хурал тухайн хуулийг хүчингүй болсонд тооцох бөгөөд энэ тухай саналаа иргэд, бусад байгууллага хууль санаачлагчид уламжлах эрхтэй. (Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Хорин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг) Түүнчлэн Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн эрх зүйн бусад актыг Үндсэн хуульд харшилсан бол холбогдох эрх бүхий этгээд хүчингүй болсонд тооцохоор байна.

Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл даган мөрдөж ирсэн бөгөөд мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй БНМАУ-ын олон улсын гэрээг Монгол Улс цаашид нэгэн адил дагаж мөрдөх, харин олон улсын гэрээ буюу түүний заалт Үндсэн хуульд харшилбал тэдгээрийг Үндсэн хуульд нийцүүлэх асуудлыг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, тухайн гэрээнд заасан болзол, журмын дагуу 1993 онд багтаан шийдвэрлэхээр зохицуулсан. (Хавсралт хуулийн Зургадугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг)

Хавсралт хуулийн Долдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд тодорхойлсон хүний эрхийг дордуулсан заалт бүхий БНМАУ-ын хууль болон олон улсын гэрээ, тэдгээрийн заалтыг мөнхүү Үндсэн хууль хүчин төгөлдөр болсноос хойш хэрэглэхийг хориглоно. ...” гэжээ. Өөрөөр хэлбэл, БНМАУ-ын хууль болон олон улсын гэрээ, тэдгээрийн заалт Үндсэн хуульд тодорхойлсон хүний эрхийг дордуулсан гэж үзвэл шүүх эсхүл бусад байгууллага түүнийг хэрэглэхгүй байна.



4.5.Хавсралт хуулийн дагуу хууль, олон улсын гэрээ, эрх зүйн акт Үндсэн хуульд харшлаагүй, хүний эрхийг дордуулаагүй байх ёстой бөгөөд энэ талаар маргавал түүнийг Үндсэн хуулийн Жаран дөрөв, Жаран зургадугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуулийн цэц харьяалан шийдвэрлэхээр байна. Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл буюу 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө дагаж мөрдөж ирсэн БНМАУ-ын хууль, олон улсын гэрээ, эрх зүйн акт Үндсэн хуульд харшилсан эсэх, мөн хууль болон олон улсын гэрээ Үндсэн хуульд тодорхойлсон хүний эрхийг дордуулсан эсэх талаар маргах боломжийг үгүйсгэх аргагүй юм. Ийм асуудлаар иргэд өргөдөл, мэдээлэл, эсхүл эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хүсэлт гаргавал Үндсэн хуулийн цэцээс өөрийн бүрэн эрхийн хүрээнд маргаан үүсгэж хянан шийдвэрлэх боломжтой байх нь үндсэн хуульд ёсонд нийцнэ. Энэ нь хууль, бусад шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэх маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрх Үндсэн хуулийн дагуу Улсын Их Хуралд бус, Үндсэн хуулийн цэцэд хадгалагдаж байгаатай уялдана.

Үндсэн хуулийн хяналтыг улс төрийн байгууллагад бус, бие даасан, хараат бус шүүх эрх мэдлийн байгууллагад тусгайлан өгсөн нь 1992 оны Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал мөн. Учир нь Үндсэн хуулийн цэц нь иргэдийн өргөдөл, мэдээлэл, эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтийн дагуу Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг шүүхийн журмаар хянан шийдвэрлэх, ингэхдээ Үндсэн хуулийг мэргэжлийн үүднээс хэрэглэж, үүнийхээ үндэслэлийг бичсэний үндсэн дээр тухайн маргааныг эцэслэн шийдвэрлэж, заавал биелэгдэх, эцсийн шийдвэр гаргана. Үндсэн хуулийг зөрчсөн маргааныг шүүхийн журмаар эцэслэн шийдвэрлэдэг, бие даасан, төвийг сахисан ийм байгууллага байхгүй бол Үндсэн хууль нь дээд хууль мөн атлаа тунхаглалын шинжтэй баримт бичиг болж хувирахад хүргэнэ гэж хууль зүйн шинжлэх ухаанд үздэг байна.

## **5.Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт ба түүнийг хүлээн зөвшөөрөөгүй тухай Улсын Их Хурлын тогтоолын үндэслэл**

5.1.Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж 2020 оны 30 дугаар тогтоол гаргахдаа ийнхүү үзсэн үндэслэлээ тусгаагүй байна. Иймээс Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн үндэслэлээ Үндсэн хуулийн цэцэд ирүүлэх шаардлагатай талаар Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2024 оны 2/347 дугаар албан бичгээр мэдэгдсэн боловч Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарт “Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй буюу Улсын Их Хурлын “Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай” 2020 оны 30 дугаар тогтоолыг Улсын Их Хурлын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулж байгаа хуулиуд болох Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн



5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн “Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх журам” гэсэн 84 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн баталсан ба бүтцийн хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн “Тогтоолын төслийн бүтэц” гэсэн 36 дугаар зүйлд заасан Улсын Их Хурлын тогтоолын бүтцийн талаарх нийтлэг зохицуулалтын хүрээнд хамаарч байгаа болно.” гэжээ.

5.2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй тогтоол гаргасан бол түүний үндэслэлийг Цэц бүрэн бүрэлдэхүүнтэй хуралдаанаар маргааныг эхнээс нь дахин хэлэлцэж, Улсын Их Хурал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож тогтоол гаргана.” гэж заасан. Иймд Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн Улсын Их Хурлын мөн оны 30 дугаар тогтоолд заасан үндэслэлийг Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар хянан хэлэлцэхээр байсан боловч ийм үндэслэл уг 30 дугаар тогтоолд бичигдээгүй байна.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар маргаантай асуудлыг бүх талаас нь бүрэн дүүрэн судалж, холбогдох нотлох баримтыг бүрдүүлэн үнэлж, үндэслэл бүхий дүгнэлт гаргах бөгөөд Улсын Их Хурал уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүйн улмаас маргааныг дахин хянах тохиолдолд ийнхүү хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн үндэслэлийг Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар магадалж, эцэслэн шийдвэрлэнэ. Иймд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай Улсын Их Хурлын шийдвэрт энэ тухай үндэслэл нь бичигдсэн байх ёстой.

5.3.Улсын Их Хурлын 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 41 дүгээр тогтоолд Үндсэн хуулийн цэцийн мөн оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн үндэслэлээ дэлгэрэнгүй тусгасан жишиг байна. Үүний нэгэн адил Улсын Их Хурал цаашид Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай тогтоолдоо энэ тухай үндэслэлээ заавал бичих шаардлагатай. Үүнтэй холбогдуулан Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх журмыг боловсронгуй болгох нь зүйтэй байна.

## **6.Нэгтгэн дүгнэхэд**

6.1.Үндсэн хуульт ёс нь хууль дээдлэх зарчим (эрх зүйт төр)-ын шаардлагын нэг бөгөөд Үндсэн хуульт ардчилсан улсыг тодорхойлогч шинж юм. Монголын ард түмний эрх мэдлийг хэрэгжүүлэх зорилго бүхий Ардын Их Хурлыг ардчилсан сонгуулиар байгуулж, Монгол Улсын нутаг





дэвсгэр дээрх хамгийн дээд хүчин чадалтай хууль буюу 1992 оны Үндсэн хуулийг ард түмний бүрэн эрхт байдлыг хангасан журмаар хэлэлцэж баталсан. Үндсэн хууль нь дээд хууль болох хувьдаа ердийн хууль, бусад шийдвэр, үйл ажиллагааг өөртөө нийцсэн байхыг шаардах бөгөөд иргэний үндсэн эрхийг хамгаалж, төрийн эрх мэдэл хуваарилж, хяналт тэнцлийг хангах замаар төрийн эрх мэдэлд хязгаарлалт тогтоодог. Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт хууль, бусад шийдвэр, үйл ажиллагаа Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байхаар заасан нь үндсэн хуульд ёсыг хэрэгжүүлэх нөхцөл мөн. Харин Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх замаар энэ нөхцөлийг Үндсэн хуулийн цэц хангаж, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болохоор Үндсэн хуулийн Жаран дөрөв, Жаран зургадугаар зүйлд заажээ.

6.2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан нь Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээг цаг хугацааны хүчин зүйлээр явцууруулсан байна. Энэ зохицуулалтын дагуу 1992 оны Үндсэн хуулийг дагаж мөрдөхөөс өмнө батлагдсан хууль, бусад шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэхийг Үндсэн хуулийн цэцээс хянан шийдвэрлэх боломжгүй болгосон байгаа нь Үндсэн хуульд нийцэхгүй эсхүл үндсэн эрхийг дордуулсан хууль, бусад шийдвэр, олон улсын гэрээ Үндсэн хуулийн хяналтаас гадуур хүчин төгөлдөр үйлчилсээр байх нөхцөлийг бүрдүүлжээ. Үндсэн хуулийн хяналтын хүрээг ийнхүү хумьснаар Үндсэн хуулийн дээд хууль байх шинж, Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн Үндсэн хуульд нийцсэн байх зарчмыг алдагдуулах хууль зүйн үр дагаврыг бий болгожээ. Үндсэн хуулийг дагаж мөрдөхөөс өмнө гарсан ч хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, бусад шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэх маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх бүрэн эрхтэй байх үзэл баримтлалыг Үндсэн хууль тогтоогч баримталсан нь Үндсэн хуулийн бичвэр, Хавсралт хуулийн агуулга, Ардын Их Хурлын болон Улсын Бага хурлын хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн анхны зохицуулалт, Үндсэн хуулийн цэцийн өмнөх шийдвэр зэргээр тогтоогдож байна.

6.3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгээр Үндсэн хуулийн цэцийн хяналтын цар хүрээг 1992 оны Үндсэн хуулийг дагаж мөрдсөн цаг хугацаагаар хязгаарласан нь үндсэн хуульд ёстой зөрчилдөж байна. Үндсэн хуулийг дагаж мөрдөхөөс өмнө гарсан ч хүчин төгөлдөр хууль, бусад шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэхийг Үндсэн хуулийн цэц хянахгүй байх хууль зүйн хязгаарлалт тогтоосон нь түүний бүрэн эрхийг хязгаарлаад зогсохгүй иргэд болон эрх бүхий байгууллага, албан



тушаалтан Үндсэн хуулийн цэцэд хандах боломжид цаг хугацааны хориглолт тавьсан байна. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.” гэж заасан.

6.4. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан хууль, бусад шийдвэр төдийгүй Үндсэн хуулийг дагаж мөрдөхөөс өмнө гарсан адилтгах хууль, бусад шийдвэр (Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 02, 1994 оны 08, 1997 оны 05 дугаар дүгнэлт, 1993 оны 03 дугаар тогтоолд хянасан шиг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, БНМАУ-ын Бага Хурлаас баталсан хууль, БНМАУ-ын Засгийн газрын тогтоол зэрэг) хүчин төгөлдөр үйлчилж буй тохиолдолд тэдгээрийг Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудал нь хэзээ батлагдсан эсэхээс үл хамааран Үндсэн хуулийн цэцийн хяналтад байна. Үндсэн хуулийн цэц Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчлэхээс өмнө гарсан хууль, бусад шийдвэр, үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн Жаран дөрөв, Жаран зургадугаар зүйлээр олгосон бүрэн эрхийн хүрээнээс халихгүй болохыг тэмдэглэж байна. Тухайлбал, Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын дагуу Үндсэн хуулийг дагаж мөрдөхөөс өмнө гарсан ч хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, бусад шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцсэн эсэх маргааныг өргөдөл, мэдээлэл, хүсэлтээр хянан шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтад заасан албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлж байхдаа явуулсан үйл ажиллагааныхаа улмаас огцруулах эсхүл эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудал хянагдах ч тухайн албан тушаалтны бүрэн эрх нь дуусгавар болсон бол ийм маргааныг хянан шийдвэрлэхгүй. Үүний нэгэн адил Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийг дагаж мөрдөхөөс өмнөх албан тушаалтны бүрэн эрх дуусгавар болсон учраас тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдуулан огцруулах, эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх маргааныг хянан шийдвэрлэхгүй, харин тэдгээр албан тушаалтны гаргасан шийдвэр нь эрх зүйн хэм хэмжээ тогтоож, хүчин төгөлдөр үйлчилж буй тохиолдолд түүнийг Үндсэн хуульд нийцсэн эсэх маргааныг хянан шийдвэрлэх боломжтой. (Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт)

6.5. Үндсэн хуулийн Жаран долдугаар зүйл болон холбогдох хуульд зааснаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш үйлчлэх ерөнхий зарчимтай. Нийтлэг байдлаар Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь заавал мөрдөгдөх шинжтэй тул зарчмын хувьд тус шийдвэр нь гарсан цагаасаа хойш (ex nunc буюу одооноос эхлээд) үйлчлэх үр дагавартай. Үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэхээс бусад тохиолдолд Үндсэн хуульд нийцэхгүй аливаа хууль нь түүнийг хүчингүй



болгох хүртэл үйлчлэлтэй хэвээр байсан гэж үзвэл тухайн хуулийг Үндсэн хуульд нийцээгүй гэж тогтоосон Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь гарсан цагаасаа хойш үйлчилнэ. (Венецийн комисс, 2020, догол 44, 63)

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд нийцээгүй хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, сонгуулийн төв байгууллагын шийдвэр, түүнчлэн өмнөх шийдвэрээ Цэц хүчингүй болгосон нь тэрхүү хууль, зарлиг, шийдвэр, гэрээний улмаас учирсан хор хохирол болон бусад үр дагаврын асуудлыг шийдвэрлэх шууд үндэслэл болохгүй. Гагцхүү Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хөнгөрүүлэх үндэслэл тогтоогдсон бол Цэцийн шийдвэрийг баримтлан хэргийг зохих хууль тогтоомжийн дагуу дахин хянаж болно.” гэж Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буцаж үйлчлэх хүрээг тодорхойлсон байна. Энэ хүрээнд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хөнгөрүүлэхэд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буцаж үйлчлэх (ex tunc буюу анхнаасаа), бусад тохиолдолд уг шийдвэр гарсан цагаасаа хойш үйлчлэхээр байна. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үр дагавартай холбоотой хэрэг, маргааныг Улсын дээд шүүх хянан шийдвэрлэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг ийм агуулгаар хэрэглэснийг тэмдэглэх нь зүйтэй. (Улсын дээд шүүхийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 001/ХТ2024/0046 дугаар тогтоол) Иймд Үндсэн хуулийн цэцийн тус тогтоолын дагуу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болгосны улмаас Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө гарсан хууль, бусад шийдвэр Үндсэн хуульд нийцээгүй болохыг тогтоосон тохиолдолд Үндсэн хуулийн цэцийн энэ тухай шийдвэр гарсан цагаас хойш тэрхүү хууль, бусад шийдвэр нь хүчингүйд тооцогдоно.

6.6. Иймээс Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 01 дүгээр дүгнэлт үндэслэлтэй байх тул дээрх хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болгох нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан



шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг удирдлага болгон

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС  
ТОГТООХ нь:**

1.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай” 30 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Г.БАЯСГАЛАН**

**ГИШҮҮД**

**Ж.ЭРДЭНЭБУЛГАН  
Д.ГАНГАБААТАР  
Л.ӨЛЗИЙСАЙХАН  
О.МӨНХСАЙХАН  
Э.ЭНХТУЯА  
Ц.ЦОЛМОН  
Б.БОЛДБААТАР  
Р.БАТРАГЧАА**



## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

GOV/INF/276/Mod.1

2006 оны 2 дугаар сарын 21-ний өдөр

### БАТАЛГААНЫ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН БАГА ХЭМЖЭЭНИЙ ЦӨМИЙН МАТЕРИАЛЫН ШИНЭЧИЛСЭН ПРОТОКОЛ

IMFCIRC/153 (Corr.) баримт бичигт үндэслэн батлагдсан баталгааны тухай хэлэлцээрийн стандарт текст нь 1974 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн GOV/INF/276 (цаашид “иж бүрэн баталгааны тухай хэлэлцээр” гэнэ) баримт бичгийн хавсралт А-д хэвлэгдсэн. IMFCIRC/153 (Corr.) баримт бичигт тодорхойлогдсон бага хэмжээний цөмийн материалтай, эсхүл цөмийн материалгүй болон цөмийн байгууламжид цөмийн материалгүй байсан улстай байгуулах хэлэлцээрийн протоколын стандарт текстийг GOV/INF/276 баримт бичгийн Хавсралт В-д заасан. Тус протокол нь нийтэд “Бага хэмжээний цөмийн материалын протокол” (БХЦМП) гэж нэрлэгддэг. БХЦМП-ын зорилго нь иж бүрэн баталгааны тухай хэлэлцээрт заасан нарийвчилсан журмын хэрэгжилтийг тэдгээр шалгуур үзүүлэлтүүдийг тухайн улс хангах хүртэл хугацаанд түрдгэлзүүлэхэд оршино.

Ерөнхий Захирал 2005 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Удирдах зөвлөлд хийсэн GOV/2005/33 дугаартай тайландаа БХЦМП-ын хязгаарлалтууд нь баталгааны тогтолцоог бэхжүүлэх хүчин чармайлттай зөрчилдөж байгааг онцолсон. Удирдах зөвлөлөөс БХЦМП-ын одоогийн хувилбар нь баталгааны тогтолцоонд сул тал үүсгэж байгааг хүлээн зөвшөөрч, БХЦМП-ыг Агентлагийн баталгааны тогтолцооны нэгэн хэсэг хэмээн хэвээр үлдээн, GOV/2005/33 баримт бичгийн 7 дугаар зүйлд заасны дагуу БХЦМП-ын стандарт текст болон шалгуур үзүүлэлтийг өөрчлөх нь зүйтэй хэмээн 2005 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр шийдвэрлэсэн байна. Түүнчлэн, Удирдах зөвлөл цаашид зөвхөн шинэчлэн найруулсан стандарт текстэд үндэслэсэн БХЦМП-ыг баталгаажуулах шийдвэр гаргасан.

GOV/2005/33 баримт бичгийн 7 дугаар зүйлд оруулсан өөрчлөлтөд:

- (i) Байгуулагдахаар төлөвлөгдсөн, эсхүл үйл ажиллагаа явуулж буй байгууламжтай улс орон БХЦМП байгуулах боломжгүй байх;
- (ii) Улсууд цөмийн материалын анхны тайлангаа гаргаж өгөх, загварын мэдээллийг урьдчилан Удирдах зөвлөлийн GOV/2554/Att.2/Rev.2 баримт бичигт нийцүүлэн мэдүүлэх шаардлагатай;
- (iii) Хяналт шалгалт хийх боломжoor хангах тухай заасан байна.

БХЦМП-ын шинэчлэн найруулсан стандарт текстийг энэхүү баримтад хавсаргав.

-----oOo-----



## ХАВСРАЛТ В

### GOV/INF/276 БАРИМТ БИЧГИЙН ХАВСРАЛТ А-Д ҮНДЭСЛЭН БАТАЛСАН ХЭЛЭЛЦЭЭРИЙН НЭМЭЛТ ПРОТОКОЛЫН БАГА ХЭМЖЭЭНИЙ ЦӨМИЙН МАТЕРИАЛЫН ШИНЭЧИЛСЭН ПРОТОКОЛ

.....улс (цаашид “.....” гэх) болон Олон улсын атомын энергийн агентлаг (“Агентлаг” гэх) нар нь дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов.

I. (1) .....болох хүртэл:

(i) Өөрийн нутаг дэвсгэр дээр, эсхүл өөрийн харьяалах газар нутагт, эсхүл хяналтад нь байдаг аливаа нутаг дэвсгэр дээрх энхийн зориулалттай цөмийн үйл ажиллагаанд ашиглах цөмийн материал нь Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдуулан..... улс болон Агентлаг нарын хооронд байгуулсан Баталгаа хэрэглэх тухай хэлэлцээр (цаашид “Хэлэлцээр” гэх)-ийн 36 дугаар зүйлд тухайн төрлийн материалын хувьд заасан хязгаараас хэтэрсэн хэмжээтэй цөмийн материал болох, эсхүл

(b) Тодорхойлолт хэсэгт тодорхойлсон байгууламжийг барих, эсхүл барих зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн бол

32-38, 40, 48, 49, 59, 61, 67, 68, 70, 72-76, 82, 84-90, 94 болон 95 дугаар зүйлээс бусад Хэлэлцээрийн II дугаар хэсгийн зүйл, заалтуудын хэрэгжилтийг түдгэлзүүлнэ.

(2) Хэлэлцээрийн 33 дугаар зүйлийн (a) болон (b) хэсгийн дагуу тайлагнах мэдээллүүдийг нэгтгэж, жил бүр тайлангаар хүргүүлэх, мөн шаардлагатай бол 33 дугаар зүйлийн (c) хэсэгт заасан цөмийн материалын импорт болон экспорттой холбоотой тайланг жил бүр хүргүүлнэ.

(3) ..... улс нь Хэлэлцээрийн 38 дугаар зүйлд заасан Нэмэлт хэлцлүүдийг тухай бүр цаг алдалгүй байгуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор:

(a) Өөрийн нутаг дэвсгэр дээр, өөрийн харьяалах газар



нутагт, эсхүл хяналтад нь байдаг аливаа нутаг дэвсгэр дээрх (1) хэсэгт тодорхойлсон хязгаараас хэтэрсэн хэмжээтэй энхийн зориулалттай цөмийн үйл ажиллагаанд ашиглах цөмийн материалыг Агентлагт урьдчилан, хангалттай хэмжээнд мэдэгдэх; эсхүл

(b) Байгууламж барих, эсхүл барих зөвшөөрөл олгох шийдвэр гарсан даруйд Агентлагт мэдэгдэх;

аль түрүүнд үүссэн нөхцөлийг мэдэгдэнэ.

II. Энэхүү протоколд .....Улс болон Агентлагийн төлөөлөгчид гарын үсэг зурах бөгөөд тус протокол нь Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдөр хүчин төгөлдөр болно.



## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ ЦӨМИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ КОНВЕНЦ

Удиртгал

Хэлэлцэн тохиролцогч талууд,

- (i) цөмийн энергийг аюулгүй, бүрэн хяналттай, байгаль орчинд ээлтэй байдлаар ашиглах нөхцөлийг хангах нь олон улсын хамтын нийгэмлэгт чухал болохыг ухамсарлан;
- (ii) дэлхий дахинд цөмийн аюулгүй ажиллагааг өндөр түвшинд хангах асуудлыг үргэлжлүүлэн хөхиүлэн дэмжих шаардлага байгааг дахин баталж;
- (iii) аливаа нэг цөмийн байгууламжийг харьяалах улс тухайн байгууламжийн цөмийн аюулгүй ажиллагааг хангах үүрэг хариуцлагатай болохыг дахин баталж;
- (iv) цөмийн аюулгүй ажиллагааны үр нөлөө бүхий соёл, ухамсарыг дэлгэрүүлэхийг эрмэлзэн;
- (v) цөмийн байгууламжид гарсан осол нь хил дамнасан үр дагавартай байж болохыг ухамсарлан;
- (vi) Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц (1979 он), Цөмийн ослын талаар шуурхай мэдээлэх тухай конвенц (1986 он), Цөмийн болон цацрагийн аюултай байдал бий болсон тохиолдолд тусламж үзүүлэх тухай конвенц (1986 он)-ыг санан;
- (vii) одоогийн хоёр болон олон талт механизм болон энэхүү шинэ конвенцоор дамжуулан цөмийн аюулгүй ажиллагааг бэхжүүлэх талаарх олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь чухал ач холбогдолтойг дахин нотолж;
- (viii) энэхүү конвенц нь аюулгүй ажиллагааны нарийвчилсан стандарт гэхээсээ илүүтэй цөмийн байгууламжийн аюулгүй ажиллагааны суурь зарчмуудыг мөрдөх үүргийг бий болгож байгаа бөгөөд үүний зэрэгцээ олон улсын түвшинд боловсруулсан аюулгүй ажиллагааны удирдамж, заавар (тухай бүр шинэчилж буй) нь аюулгүй ажиллагааг дээд зэргээр хангах орчин үеийн арга хэрэгслийн талаар заавар, зөвлөмжөөр хангаж болохыг хүлээн зөвшөөрч;





- (ix) хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааг хангах хөрс суурийг бий болгоход чиглэсэн эдүгээгийн үйл хэрэг нь олон улсыг хамарсан нэгдсэн тохиролцоонд хүрсэн тохиолдолд цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааг хангах тухай олон улсын конвенцыг боловсруулах ажлыг даруй эхлүүлэх шаардлага байгааг нотлон;
- (x) цөмийн түлшний циклийн бусад хэсгийн аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр цаашид хийх техник ажлын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, энэхүү ажил нь яваандаа хүчин төгөлдөр үйлчилж буй, эсхүл ирээдүйд байгуулагдах олон улсын эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгоход дөхөм үзүүлж болохыг зөвшөөрч,

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

## **1 ДҮГЭЭР БҮЛЭГ ЗОРИЛГО, ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ**

### **1 дүгээр зүйл Зорилго**

Энэхүү конвенцын зорилго нь:

- (i) үндэсний арга хэмжээ болон олон улсын хамтын ажиллагаа, түүний дотор шаардлагатай үед аюулгүй ажиллагааны техникийн хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар дэлхий дахинд цөмийн аюулгүй ажиллагааг дээд зэргээр хангах, тогтвортой хадгалах;
- (ii) цөмийн байгууламжаас үүсэх ионжуулагч цацрагийн хортой нөлөөнөөс хувь хүн, нийгэм болон байгаль орчныг хамгаалах зорилгоор болзошгүй цацрагийн аюулын эсрэг үр ашигтай хамгаалалтыг цөмийн байгууламжуудад бий болгох, хэрэгжүүлэх;
- (iii) цацрагийн сөрөг үр дагавар бүхий ослоос урьдчилан сэргийлэх болон осол гарсан тохиолдолд хор уршгийг бууруулахад оршино.

### **2 дугаар зүйл Тодорхойлолт**

Энэхүү конвенцын хүрээнд:

- (i) “цөмийн байгууламж” гэж энэхүү конвенцын Хэлэлцэн тохиролцогч тал бүрийн хувьд түүний харьяалалд байгаа, газрын хөрсөн дээр байрлах энхийн зориулалттай цөмийн цахилгаан станц,



түүнчлэн тухайн цөмийн цахилгаан станцын үйл ажиллагаатай шууд холбоотой, түүнтэй нэг талбайд байрлах цацраг идэвхт материалыг хадгалах, бэлтгэх болон боловсруулах байгууламжийг хэлнэ. Реакторын голомтоос цөмийн түлшний бүх элементийг бүрмөсөн тусгаарлаж, тогтоосон журмын дагуу аюулгүй болгон хадгалсан бөгөөд тухайн станцыг ашиглалтаас гаргах хөтөлбөрийг зохицуулагч байгууллагаас зөвшөөрсөн нөхцөлд тухайн станц нь цөмийн байгууламж гэж тооцогдохоо болино.

- (ii) “зохицуулагч байгууллага” гэж энэхүү конвенцын Хэлэлцэн тохиролцогч тал бүрийн хувьд тусгай зөвшөөрөл олгох болон цөмийн байгууламжийг барих газрыг сонгох, зураг төсөл боловсруулах, барьж байгуулах, ашиглалтад оруулах, ажиллуулах, эсхүл ашиглалтаас гаргах асуудлыг зохицуулах хууль ёсны бүрэн эрхийг Хэлэлцэн тохиролцогч тухайн талаас олгосон байгууллага, эсхүл байгууллагуудыг хэлнэ.
- (iii) “тусгай зөвшөөрөл” гэж цөмийн байгууламжийг барих газрыг сонгох, зураг төсөл боловсруулах, барьж байгуулах, ашиглалтад оруулах, ажиллуулах, эсхүл ашиглалтаас гаргах үүрэг, хариуцлагыг хүлээлгэхээр өргөдөл гаргагчид зохицуулагч байгууллагаас олгосон аливаа зөвшөөрлийг хэлнэ.

### **3 дугаар зүйл Үйлчлэх хүрээ**

Энэхүү конвенц нь цөмийн байгууламжийн аюулгүй ажиллагааг хангахад үйлчилнэ.

### **2 ДУГААР БҮЛЭГ ҮҮРЭГ**

- (a). Ерөнхий заалт

### **4 дүгээр зүйл Хэрэгжүүлэх арга хэмжээ**

Хэлэлцэн тохиролцогч тал бүр үндэснийхээ хууль тогтоомжийн хүрээнд энэхүү конвенцын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай эрх зүйн, зохицуулалтын болон захиргааны арга хэмжээ болоод шаардлагатай бусад алхмыг авч хэрэгжүүлнэ.



## 5 дугаар зүйл Тайлан

Хэлэлцэн тохиролцогч тал бүр энэхүү конвенцын 20 дугаар зүйлд заасан хурал бүрийн өмнө конвенцын дагуу хүлээсэн үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг хянуулахаар хүргүүлнэ.

## 6 дугаар зүйл Ашиглаж буй цөмийн байгууламж

Хэлэлцэн тохиролцогч тал бүр энэхүү конвенц тухайн талын хувьд хүчин төгөлдөр болох үед өөрийн ашиглаж буй цөмийн байгууламжийн аюулгүй ажиллагааг аль болох хурдан хянаж үнэлэх чиглэлээр зохих арга хэмжээг авна.

Энэхүү конвенцын зорилгыг хангах хүрээнд шаардлагатай бол Хэлэлцэн тохиролцогч тал цөмийн байгууламжийн аюулгүй ажиллагааг шинэчлэх үүднээс хэрэгжүүлж болох бүхий л сайжруулалтын арга хэмжээг яаралтай хэрэгжүүлнэ. Хэрэв ийм шинэчлэлийг хийх боломжгүй бол тухайн цөмийн байгууламжийг хаах төлөвлөгөөг аль болох хурдан хэрэгжүүлнэ. Байгууламжийг хаах цаг хугацааг тодорхойлохдоо эрчим хүчний цогц асуудал, боломжит бусад хувилбар болоод түүнийг хааснаас үүдэн гарах байгаль орчин болон нийгэм, эдийн засгийн үр нөлөө зэргийг харгалзан үзэж болно.

(б). Хууль тогтоомж болон зохицуулалт

## 7 дугаар зүйл Эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоо

1.Хэлэлцэн тохиролцогч тал бүр цөмийн байгууламжийн аюулгүй ажиллагааг хангах харилцааг зохицуулсан эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоог бий болгож хэрэгжүүлнэ.

2.Эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоо нь дараах зохицуулалтыг агуулсан байна. Үүнд:

- (i) аюулгүй ажиллагааг хангахад тавигдах үндэсний шаардлага болон дүрэм, журмыг бий болгосон байх;
- (ii) цөмийн байгууламжийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ажиллуулах болон тусгай зөвшөөрөлгүйгээр ажиллуулахыг хориглосон тогтолцоог бүрдүүлсэн байх;



- (iii) холбогдох дүрэм, журам болон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор цөмийн байгууламжид зохицуулагч байгууллагын хяналт шалгалт, үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлсэн байх;
- (iv) холбогдох дүрэм, журам болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, түүний дотор тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлэх, өөрчлөх, эсхүл хүчингүй болгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг байх.

### **8 дугаар зүйл** **Зохицуулагч байгууллага**

1.Хэлэлцэн тохиролцогч тал бүр 7 дугаар зүйлд заасан эрх зүйн болон зохицуулалтын тогтолцооны хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүрэг бүхий зохицуулагч байгууллагыг шинээр байгуулах, эсхүл томилох бөгөөд хүлээсэн чиг үүргээ биелүүлэхэд нь шаардагдах хангалттай хэмжээний эрх мэдэл, чадавх, санхүүгийн болон хүний нөөцөөр хангана.

2.Хэлэлцэн тохиролцогч тал бүр зохицуулагч байгууллага болон цөмийн эрчим хүчийг ашиглах, эсхүл ашиглахыг дэмжих зорилготой аливаа бусад байгууллагын чиг үүргийг хооронд нь сайтар зааглахад чиглэсэн арга хэмжээ авна.

### **9 дүгээр зүйл** **Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг, хариуцлага**

Хэлэлцэн тохиролцогч тал бүр цөмийн байгууламжийн аюулгүй ажиллагааг хангах үндсэн үүргийг холбогдох тусгай зөвшөөрлийг эзэмшигч хүлээдэг байх, түүнчлэн тэдгээр тусгай зөвшөөрөл эзэмшигч бүр хүлээсэн үүргээ биелүүлдэг байх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна.

- (в). Аюулгүй ажиллагаатай холбоотой ерөнхий асуудал

### **10 дугаар зүйл** **Аюулгүй ажиллагааг тэргүүн ээлжид хангах**

Хэлэлцэн тохиролцогч тал бүр цөмийн байгууламжтай шууд холбоотой үйл ажиллагаа эрхэлж буй бүх байгууллага цөмийн аюулгүй ажиллагааг тэргүүн ээлжид хангах бодлого боловсруулж мөрдөх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна.



### **11 дүгээр зүйл Санхүүгийн болон хүний нөөц**

1.Хэлэлцэн тохиролцогч тал бүр цөмийн байгууламж нэг бүрийн ашиглалтын хугацааны туршид тэдгээрийн аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай санхүүгийн хүрэлцэхүйц нөөцтэй байх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна.

2.Хэлэлцэн тохиролцогч тал бүр цөмийн байгууламж нэг бүрийн ашиглалтын хугацааны туршид тэдгээрийн аюулгүй ажиллагааг хангахтай холбоотой бүх үйл ажиллагаанд шаардлагатай зохих түвшний боловсрол эзэмшсэн, сургалт болон дахин сургалтад хамрагдсан хүрэлцэхүйц тооны мэргэжлийн боловсон хүчинтэй байх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна.

### **12 дугаар зүйл Хүний хүчин зүйл**

Хэлэлцэн тохиролцогч тал бүр цөмийн байгууламж нэг бүрийн ашиглалтын хугацааны туршид хүний ажил гүйцэтгэх хүчин чадал болон түүний хэмжээ хязгаарыг харгалзан үзэх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна.

### **13 дугаар зүйл Чанарын баталгаа**

Хэлэлцэн тохиролцогч тал бүр цөмийн байгууламж нэг бүрийн ашиглалтын хугацааны туршид цөмийн аюулгүй ажиллагааг хангахад ач холбогдолтой бүх үйл ажиллагаанд тавигдах тодорхой шаардлагуудыг дагаж биелүүлж байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор чанарын баталгааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд чиглэсэн зохих арга хэмжээг авна.

### **14 дүгээр зүйл Аюулгүй ажиллагааны үнэлгээ хийх, баталгаажуулах**

Хэлэлцэн тохиролцогч тал бүр дараах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (i) цөмийн байгууламжийг барьж байгуулах, түүнийг ашиглалтад оруулахын өмнө болон ашиглалтын хугацааны туршид аюулгүй ажиллагааны иж бүрэн, системтэй үнэлгээ хийх. Ийм үнэлгээг сайтар баримтжуулах шаардлагатай бөгөөд үйл ажиллагааны явцад хуримтлуулсан туршлага болон аюулгүй ажиллагаанд ач холбогдолтой шинэ мэдээллийг харгалзан тогтмол шинэчлэх ба



түүнийг зохицуулагч байгууллагын зүгээс эрх мэдлийнхээ хүрээнд хянаж байх.

- (ii) цөмийн байгууламжийн биет байдал, түүний үйл ажиллагаа нь зураг төсөл, аюулгүй ажиллагааны холбогдох үндэсний шаардлагууд болон үйл ажиллагааны нөхцөл, хориг хязгаарлалтад нийцэж буй эсэхийг судалгаа шинжилгээ явуулах, туршилт, шалгалт хийх замаар тогтоож баталгаажуулах.

### **15 дугаар зүйл Цацрагийн хамгаалалт**

Хэлэлцэн тохиролцогч тал бүр цөмийн байгууламжийн үйл ажиллагааны бүхий л үе шатанд тухайн байгууламжаас тэнд ажиллагсад болон хүн амд үзүүлэх цацрагийн шарлагыг байж болохуйц хамгийн бага хэмжээнд байлгах, нэг ч хүн үндэсний стандартаар тогтоосон тунгийн хязгаараас хэтэрсэн цацрагийн нөлөөнд өртөхгүй байх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна.

### **16 дугаар зүйл Ослын үеийн бэлэн байдал**

1.Хэлэлцэн тохиролцогч тал бүр ослын үед голомт дээр болон байгууламжийн гадна хэрэгжүүлэх үйл ажиллагааг хамарсан ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, цөмийн байгууламжид тогтмол туршиж байх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг Хэлэлцэн тохиролцогч тал бүр авна.

Цөмийн аливаа шинэ байгууламж бүрд уг төлөвлөгөөг боловсруулж, тус байгууламжийг ажиллуулж эхлэхийн өмнө зохицуулагч байгууллагаас тогтоосон эрчим хүчний доод түвшнээс илүү утгад турших шаардлагатай.

2.Цацрагийн осолд өртөх магадлалтай байвал цөмийн байгууламжийн хөрш зэргэлдээ орших өөрийн хүн ам болон эрх бүхий байгууллагуудыг ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө болон авах хариу арга хэмжээний талаар зохих мэдээллээр хангахад чиглэсэн зохих арга хэмжээг Хэлэлцэн тохиролцогч тал бүр авна.

3.Өөрийн нутаг дэвсгэр дээр цөмийн байгууламжгүй Хэлэлцэн тохиролцогч талууд түүний хөрш зэргэлдээ орших цөмийн байгууламжид үүссэн цацрагийн осолд өртөх магадлалтай байвал ослын үед өөрийн нутаг дэвсгэрт авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг хамарсан арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, турших чиглэлээр зохих арга хэмжээг авна.

(г). Байгууламжийн аюулгүй ажиллагаа

**17 дугаар зүйл**  
**Байршил сонгох**

Хэлэлцэн тохиролцогч тал бүр дараах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих журмуудыг бий болгож, хэрэгжүүлэхэд чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (i) цөмийн байгууламжийн ашиглалтын хугацаанд түүний аюулгүй ажиллагаанд нөлөөлж болзошгүй байршилтай холбоотой бүх хүчин зүйлийг үнэлж тооцоолох;
- (ii) шинээр барих цөмийн байгууламжийн хувь хүн, нийгэм болон байгаль орчинд учруулж болзошгүй аюулгүй ажиллагааны нөлөөллийг үнэлж тооцоолох;
- (iii) цөмийн байгууламжийн аюулгүй ажиллагааг тогтмол хангах үүднээс (I) болон (II) заалтад дурдсан бүх хүчин зүйлийг дахин үнэлж тооцоолох;
- (iv) шинээр барих цөмийн байгууламж нь түүний хөрш зэргэлдээ орших Хэлэлцэн тохиролцогч талуудад нөлөөлж болзошгүй учир тухайн Хэлэлцэн тохиролцогч талуудтай зөвлөлдөх, хүсэлт гаргасан тохиолдолд тэдгээр талуудыг шаардлагатай мэдээллээр хангаж, уг байгууламжаас нутаг дэвсгэрт нь үзүүлж болзошгүй аюулгүй байдлын нөлөөллийг үнэлж тооцоолох боломжийг олгох.

**18 дугаар зүйл**  
**Зураг төсөл боловсруулах болон барьж байгуулах**

Хэлэлцэн тохиролцогч тал бүр дараах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (i) цөмийн байгууламжийн зураг төсөл боловсруулах болон барьж байгуулахдаа ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд цацрагийн үр дагаврыг бууруулах үүднээс цацраг идэвхт материалын тархалтын эсрэг тодорхой үе шатлалтайгаар авах хамгаалалтын хэд хэдэн найдвартай арга хэрэгсэл (нарийвчилсан хамгаалалт)-ийг төлөвлөж бий болгох;
- (ii) цөмийн байгууламжийн зураг төсөл боловсруулах, барьж байгуулахад ашиглах технологи нь туршлагаар батлагдсан, эсхүл туршилт болон дүн шинжилгээгээр шаардлага хангасан байх;



- (iii) цөмийн байгууламжийн зураг төсөл нь байгууламжийг найдвартай, тогтвортой, хялбар удирдаж ажиллуулдаг байхаар хийгдсэн байх бөгөөд чингэхдээ хүний хүчин зүйл болон хүн төхөөрөмжтэй хялбар харьцах боломжтой байхад тусгайлан анхаарч тооцсон байх.

### 19 дүгээр зүйл Байгууламжийг ажиллуулах

Хэлэлцэн тохиролцогч тал бүр дараах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (i) цөмийн байгууламжийг ажиллуулах анхны зөвшөөрлийг тус байгууламж зураг төсөл болон аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн эсэхийг нотолсон зохих аюулгүй ажиллагааны дүн шинжилгээ болон ашиглалтад оруулах хөтөлбөрт үндэслэж олгодог байх;
- (ii) аюулгүй ажиллагааны дүн шинжилгээ, туршилт болон үйл ажиллагааны туршлагад үндэслэн үйл ажиллагааны нөхцөл, зааг хязгаарыг тодорхойлж, шаардлагатай бол үйл ажиллагааны аюулгүйн хэмжээ заагийг тогтоох үүднээс хянан шинэчилж байх;
- (iii) цөмийн байгууламжийг ажиллуулах, ашиглах, хяналт шалгалт хийх болон турших ажиллагааг тогтоосон журмын дагуу явуулах;
- (iv) үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэл болон ослын эсрэг авах хариу арга хэмжээний журмыг бий болгох;
- (v) цөмийн байгууламжийн ашиглалтын хугацааны туршид түүний аюулгүй ажиллагааг хангахтай холбоотой бүх салбарт шаардлагатай инженер, техникийн нөөцтэй байх;
- (vi) тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд нь аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөх тохиолдлын талаар хяналтын байгууллагад цаг алдалгүй мэдэгдэж байх;
- (vii) үйл ажиллагааны туршлага хуримтлуулж, түүнд дүн шинжилгээ хийхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулах, түүний дүнд олж авсан үр дүн болон гарсан дүгнэлтийн мөрөөр арга хэмжээ авах, мөн хүчин төгөлдөр үйлчилж буй механизмаар дамжуулан олон улсын байгууллага, холбогдох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бусад байгууллага болон зохицуулагч байгууллагатай чухал ач холбогдолтой туршлагын талаар хуваалцах;



- (viii) цөмийн байгууламжийн үйл ажиллагаанаас гарах цацраг идэвхт хаягдлыг цацрагийн түвшин болон овор хэмжээний хувьд практикт байж болохуйц хамгийн бага түвшинд барьж байх, цөмийн байгууламжийн үйл ажиллагаатай шууд холбоотой, тухайн байгууламж байрлаж буй газарт байгаа ашигласан түлш болон хаягдлыг хадгалах, аливаа шаардлагатай боловсруулалт хийхэд тэдгээрийг зохистой төлөвт оруулах болон булшлах асуудлыг харгалзан үзэх.

### **3 ДУГААР БҮЛЭГ ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХУРАЛ**

#### **20 дугаар зүйл Тайлан хэлэлцэх хурал**

1.Хэлэлцэн тохиролцогч талууд 5 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлсэн тайланг 22 дугаар зүйлийн дагуу баталсан журмын дагуу хэлэлцэх зорилгоор хурал (цаашид “Тайлан хэлэлцэх хурал” гэх) зохион байгуулна.

2.Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, тайлан хэлэлцэх хурлын үеэр тайланд туссан тодорхой асуудлыг хэлэлцэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч талуудын төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын дэд хэсгийг 24 дүгээр зүйлийн заалтыг харгалзан байгуулж, ажиллуулж болно.

3.Хэлэлцэн тохиролцогч тал бүр бусад талаас ирүүлсэн тайланг хэлэлцэх, тайлангийн талаар тодруулга авах бодит боломжоор хангагдана.

#### **21 дүгээр зүйл Хуваарь**

1.Хэлэлцэн тохиролцогч талуудын бэлтгэл хурлыг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дотор зохион байгуулна.

2.Энэхүү бэлтгэл хурлаар Хэлэлцэн тохиролцогч талууд тайлан хэлэлцэх анхны хурлын товыг тогтооно. Тайлан хэлэлцэх анхны хурлыг аль болох богино хугацааны дотор, гэхдээ энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гучин сараас хэтрэхгүй хугацааны дотор зохион байгуулна.

3.Тайлан хэлэлцэх хурал хийх бүрд Хэлэлцэн тохиролцогч талууд дараагийн хурлын товыг тогтооно. Тайлан хэлэлцэх хурал хоорондын хугацаа нь гурван жилээс хэтрэхгүй байна.



## 22 дугаар зүйл Үйл ажиллагааны зохицуулалт

1. 21 дүгээр зүйлд заасны дагуу хуралдсан бэлтгэл хурлаар Хэлэлцэн тохиролцогч талууд Үйл ажиллагааны дүрэм болон Санхүүгийн дүрмээ боловсруулж, санал нэгтгэйгээр батална. Хэлэлцэн тохиролцогч талууд Үйл ажиллагааны дүрэмд нийцүүлэн дараах зүйлсийг тусгайлан тогтооно. Үүнд:

- (i) 5 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлэх тайлангийн хэлбэр, бүтцийн талаарх зааварчилгаа;
- (ii) тэрхүү тайланг хүргүүлэх өдөр;
- (iii) тэрхүү тайланг хэлэлцэх үйл ажиллагааны дэг.

2. Шаардлагатай тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч талууд тайлан хэлэлцэх хурлаар дээрх (i)-(iii) заалтын дагуу тогтоосон зохицуулалтыг дахин хянан хэлэлцэж болох бөгөөд Үйл ажиллагааны дүрэмд өөрөөр заагаагүй бол санал нэгтгэйгээр шинэчлэн баталж болно. Түүнчлэн Үйл ажиллагааны дүрэм болон Санхүүгийн дүрэмд санал нэгтгэйгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

## 23 дугаар зүйл Ээлжит бус хурал

Хэлэлцэн тохиролцогч талуудын ээлжит бус хурлыг:

- i. хуралд оролцож, санал өгсөн Хэлэлцэн тохиролцогч талуудын олонхын саналаар ээлжит бус хурал хийхээр тохиролцсон бол /үүнд, санал өгөхөөс татгалзсаныг санал өгсөнд тооцно/; эсхүл
- ii. Хэлэлцэн тохиролцогч аль нэг талаас ээлжит бус хурал хийх хүсэлт гаргаж, уг хүсэлтийг 28 дугаар зүйлд заасан Нарийн бичгийн дарга нарын газар Хэлэлцэн тохиролцогч талуудад мэдэгдсэн бөгөөд Хэлэлцэн тохиролцогч талуудын олонх нь хүсэлтийг дэмжиж буйгаа мэдэгдсэн тохиолдолд хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш зургаан сарын дотор хуралдуулна.

## 24 дүгээр зүйл Хуралд оролцох

1. Хэлэлцэн тохиролцогч тал бүр Хэлэлцэн тохиролцогч талуудын хуралд оролцох бөгөөд тухайн талыг төлөөлөн нэг төлөөлөгч хуралд оролцоно. Шаардлагатай тохиолдолд түүнтэй адилтгах бусад төлөөлөгчид, мэргэжилтнүүд болон зөвлөхүүд оролцож болно.



2.Хэлэлцэн тохиролцогч талууд санал нэгтгэйгээр шийдвэрлэсэн тохиолдолд энэхүү конвенцоор зохицуулсан асуудал эрх хэмжээнд нь хамаарах Засгийн газар хоорондын аливаа байгууллагыг аливаа хурал, эсхүл тусгай хуралд ажиглагчаар оролцохыг урьж болно. Ажиглагч нь 27 дугаар зүйлийн заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа бичгээр урьдчилан мэдэгдэх шаардлагатай.

### **25 дугаар зүйл Тайлангийн дүгнэлт**

Хэлэлцэн тохиролцогч талууд хурлаар хэлэлцсэн асуудал болон хүрсэн дүгнэлтийг тусгасан баримт бичгийг санал нэгтгэйгээр батлах ба тухайн баримт бичгийг олон нийтэд нээлттэй байлгана.

### **26 дугаар зүйл Хэл**

1.Үйл ажиллагааны дүрэмд өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохиролцогч талуудын хурлын хэл нь араб, хятад, англи, франц, орос болон испани хэл байна.

2. 5 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлсэн тайланг түүнийг хүргүүлсэн Хэлэлцэн тохиролцогч талын албан ёсны хэлээр, эсхүл Үйл ажиллагааны дүрмээр тохирох тодорхой нэг хэлээр боловсруулна. Тайланг /Үйл ажиллагааны дүрэмд/ заасан тодорхой нэг хэлээр бус, Хэлэлцэн тохиролцогч талын албан ёсны хэлээр боловсруулсан бол тухайн Хэлэлцэн тохиролцогч тал тайлангийн тохиролцсон хэл дээрх орчуулгыг хүргүүлнэ.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас үл хамааран, Нарийн бичгийн дарга нарын газар нь хурлын бусад хэлээр боловсруулж ирүүлсэн тайланг тодорхой тохиролцсон хэлнээ орчуулах ажлыг төлбөртэйгээр гүйцэтгэж болно.

### **27 дугаар зүйл Нууцлал**

1.Энэхүү конвенцын заалтууд нь Хэлэлцэн тохиролцогч талуудын дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу эдлэх буюу хүлээх, мэдээллийг задруулахаас хамгаалах эрх, үүргийг хөндөхгүй. Энэ зүйлийг тодорхой болгох зорилгоор “мэдээлэл” гэдэгт (i) хувийн мэдээлэл, (ii) оюуны өмчийн эрхээр, эсхүл үйлдвэрлэлийн болон худалдааны нууцлалын хүрээнд хамгаалагдсан мэдээлэл болон (iii) үндэсний аюулгүй байдал, эсхүл цөмийн материал болон цөмийн байгууламжийн биет хамгаалалттай холбоотой мэдээлэл зэрэг багтана.



2. Энэхүү конвенцын хүрээнд Хэлэлцэн тохиролцогч аль нэг талаас энэ зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсны дагуу хамгаалагдсан мэдээлэл гэж тодорхойлон аливаа мэдээллийг гаргаж өгсөн тохиолдолд уг мэдээллийг зөвхөн тухайн гаргаж өгсөн зорилгоор ашиглах бөгөөд түүний нууцлалд хүндэтгэлтэй хандана.

3. Хэлэлцэн тохиролцогч талуудын тайлан хэлэлцэх хурал бүрийн үеэр өрнөсөн хэлэлцүүлгийн агуулга нууц байна.

### **28 дугаар зүйл Нарийн бичгийн дарга нарын газар**

1. Олон улсын атомын энергийн агентлаг (цаашид “Агентлаг” гэх) нь Хэлэлцэн тохиролцогч талуудын хурлын хувьд Нарийн бичгийн дарга нарын газрын үүрэг гүйцэтгэнэ.

2. Нарийн бичгийн дарга нарын газар нь:

- (i) Хэлэлцэн тохиролцогч талуудын хурлыг хуралдуулах, бэлтгэл ажлыг хангах болон хурлын үеэрх үйлчилгээг хариуцах;
- (ii) энэхүү конвенцын заалтын дагуу хүлээн авсан, эсхүл боловсруулж бэлтгэсэн мэдээллийг Хэлэлцэн тохиролцогч талуудад хүргэх үүргийг гүйцэтгэнэ.

Дээрх (i) болон (ii) заалтад заасан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан Агентлагаас гаргасан зардлыг Агентлаг өөрийн төсвийн хүрээнд хариуцна.

3. Хэлэлцэн тохиролцогч талууд санал нэгтгэйгээр Хэлэлцэн тохиролцогч талуудын хурлыг дэмжиж бусад үйлчилгээ үзүүлэхийг Агентлагаас хүсэж болно. Агентлаг нь тухайн үйлчилгээг хэрэв боломжтой бол өөрийн хөтөлбөр болон батлагдсан төсвийн хүрээнд үзүүлж болно. Хэрэв тийм боломжгүй бол Агентлаг тухайн үйлчилгээг бусад эх үүсвэрээс авах сайн дурын санхүүжилтийн үндсэн дээр үзүүлж болно.

### **4 ДҮГЭЭР БҮЛЭГ ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ БОЛОН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ**

#### **29 дүгээр зүйл Маргаан шийдвэрлэх**

Энэхүү конвенцыг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хоёр буюу түүнээс дээш Хэлэлцэн тохиролцогч талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч талууд тухайн



маргааныг шийдвэрлэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч талуудын хурлын хүрээнд зөвлөлдөнө.

**30 дугаар зүйл**  
**Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн**  
**зөвшөөрөх, батлах, нэгдэн орох**

1.Энэхүү конвенцод Вена хотод байрлах Агентлагийн төв байранд 1994 оны 9 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн түүнийг хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд бүх улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

2.Энэхүү конвенцод гарын үсэг зурсан улс түүнийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батлах үүрэгтэй.

3.Энэхүү конвенцод түүнийг хүчин төгөлдөр болсноос хойш бүх улс нэгдэн ороход нээлттэй байна.

4.

- (i) Гишүүнчлэл нь тусгаар улсуудаас бүрдэх, энэхүү конвенцоор зохицуулсан асуудлаар олон улсын хэлэлцээр байгуулах хэлэлцээ хийх, байгуулах, хэрэгжүүлэх эрх хэмжээ бүхий бүс нутгийн нэгдлийн буюу бусад төрлийн байгууллага энэхүү конвенцод гарын үсэг зурах, эсхүл нэгдэн ороход нээлттэй байна.
- (ii) Тэдгээр байгууллага нь эрх хэмжээнийхээ хүрээнд энэхүү конвенцын дагуу Оролцогч Улсуудын хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагыг өөрийн нэрийн өмнөөс эдэлж, хэрэгжүүлнэ.
- (iii) Энэхүү конвенцод нэгдэн орох үедээ тэрхүү байгууллага нь аль улс тухайн байгууллагын гишүүн болох, тус байгууллагын хувьд энэхүү конвенцын аль заалт үйлчлэх болон тэдгээр заалтаар зохицуулсан салбар дахь тухайн байгууллагын эрх хэмжээний талаар тусгасан мэдэгдлийг 34 дүгээр зүйлд заасан Эх хадгалагчид хүргүүлнэ.
- (iv) Тэрхүү байгууллага нь өөрийн гишүүн улсуудын саналын эрхээс гадна нэмэлт санал өгөх эрхгүй байна.

5.Соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг Эх хадгалагчид хадгалуулна.

**31 дүгээр зүйл**  
**Хүчин төгөлдөр болох**

1.Энэхүү конвенц нь түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан тухай хорин хоёр дахь батламж жуух бичгийг Эх хадгалагч хүлээн авсан өдрөөс хойш ер дэх өдөр хүчин төгөлдөр



болно. Чингэхдээ эдгээр хорин хоёр батламж жуух бичгийн арван долоо нь цөмийн реакторын голомт нь критик утгандаа хүрч ажилладаг доод тал нь нэг цөмийн байгууламж бүхий улсуудаас ирсэн байх ёстой.

2.Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан нөхцөлийг хангахад шаардлагатай сүүлийн батламж жуух бичгийг хүлээн авсан өдрөөс хойш энэхүү конвенцыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон улс, эсхүл бүс нутгийн нэгдлийн буюу бусад төрлийн байгууллагын хувьд энэхүү конвенц нь тухайн улс, эсхүл байгууллага зохих батламж жуух бичгээ Эх хадгалагчид хадгалуулсан өдрөөс хойш ер дэх өдөр хүчин төгөлдөр болно.

### **32 дугаар зүйл** **Конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах**

1.Хэлэлцэн тохиролцогч аливаа тал энэхүү конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Санал болгосон нэмэлт, өөрчлөлтийг тайлан хэлэлцэх хурал, эсхүл ээлжит бус хурлаар хэлэлцэнэ.

2.Санал болгосон аливаа нэмэлт, өөрчлөлтийн бичвэр болон нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэлийг Эх хадгалагчид хүргүүлнэ. Эх хадгалагч нь тухайн нэмэлт, өөрчлөлтийн төслийг Хэлэлцэн тохиролцогч талуудад шуурхай тараах бөгөөд чингэхдээ тухайн асуудлыг хэлэлцэх хурал болохоос дор хаяж ер хоногийн өмнө тараасан байх шаардлагатай. Тухайн нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулан ирүүлсэн аливаа саналыг Эх хадгалагч Хэлэлцэн тохиролцогч талуудад тараана.

3.Хэлэлцэн тохиролцогч талууд нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцсэний үндсэн дээр тухайн нэмэлт, өөрчлөлтийг батлах эсэх асуудлыг санал нэгтгэйгээр шийдвэрлэх бөгөөд тийнхүү санал нэгтгэйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд уг асуудлыг Дипломат зөвлөгөөнөөр хэлэлцүүлэх эсэх шийдвэрийг гаргана. Нэмэлт, өөрчлөлтийн төслийг Дипломат зөвлөгөөнөөр хэлэлцүүлэх шийдвэрийг тухайн хуралд оролцож, саналаа өгсөн Хэлэлцэн тохиролцогч талуудын гуравны хоёрын саналаар гаргах бөгөөд чингэхдээ тухайн хурлаар санал хураах үед Хэлэлцэн тохиролцогч бүх талын талаас доошгүй хувь нь оролцсон байх ёстой. Санал өгөхөөс татгалзсаныг санал өгсөнд тооцно.

4.Энэхүү конвенцод оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, батлах Дипломат зөвлөгөөнийг Эх хадгалагч зарлан хуралдуулах бөгөөд чингэхдээ энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу зохих шийдвэр гарснаас хойш нэг жилийн дотор хуралдуулна. Дипломат зөвлөгөөн нь тухайн нэмэлт, өөрчлөлтийг аль болох санал нэгтгэйгээр батлах нөхцөлийг хангахад чиглэсэн шаардлагатай бүх арга хэмжээг авна. Хэрэв санал нэгтгэйгээр баталж чадахгүй бол Хэлэлцэн тохиролцогч бүх талын гуравны хоёрын саналаар нэмэлт, өөрчлөлтийг батална.



5.Хэлэлцэн тохиролцогч талууд энэ зүйлийн 3 болон 4 дэх хэсэгт заасны дагуу баталсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл батламжлах бөгөөд нэмэлт, өөрчлөлт нь түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл батламжилсан Хэлэлцэн тохиролцогч талын хувьд Хэлэлцэн тохиролцогч талуудын дөрөвний гурав нь соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл батламжилсан тухай батламж жуух бичгээ Эх хадгалагчид хүргүүлсэн өдрөөс хойш ер дэх өдөр хүчин төгөлдөр болно. Нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа уг нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл батламжилсан Хэлэлцэн тохиролцогч талын хувьд нэмэлт, өөрчлөлт нь тухайн тал энэ тухай батламж жуух бичгээ Эх хадгалагчид хүргүүлсэн өдрөөс хойш ер дэх өдөр хүчин төгөлдөр болно.

### **33 дугаар зүйл Цуцлах**

1.Хэлэлцэн тохиролцогч аливаа тал Эх хадгалагчид бичгээр мэдэгдэл хүргүүлэх замаар энэхүү конвенцыг цуцалж болно.

2.Ийнхүү цуцлах нь энэ тухай мэдэгдлийг Эх хадгалагч хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа, эсхүл мэдэгдэлд тусгайлан заасан түүнээс хойшхи өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

### **34 дүгээр зүйл Эх хадгалагч**

1.Агентлагийн Ерөнхий захирал нь энэхүү конвенцын Эх хадгалагч байна.

2.Эх хадгалагч нь Хэлэлцэн тохиролцогч талуудыг дараах мэдээллээр хангана. Үүнд:

- (i) 30 дугаар зүйлд заасны дагуу энэхүү конвенцод гарын үсэг зурсан тухай болон түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг хүлээн авсан тухай;
- (ii) 31 дүгээр зүйлд заасны дагуу энэхүү конвенц хүчин төгөлдөр болох өдөр;
- (iii) 33 дугаар зүйлд заасны дагуу гаргасан энэхүү конвенцыг цуцлах тухай мэдэгдэл болон тухайн цуцлалт хүчинтэй болох өдөр;



- (iv) 32 дугаар зүйлд заасны дагуу энэхүү конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Хэлэлцэн тохиролцогч талуудаас ирүүлсэн санал, холбогдох Дипломат зөвлөгөөнөөр, эсхүл Хэлэлцэн тохиролцогч талуудын хурлаар баталсан нэмэлт, өөрчлөлт болон тухайн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болох өдөр.

**35 дугаар зүйл**  
**Эх бичвэр**

Энэхүү конвенцын араб, хятад, англи, франц, орос болон испани хэлээрх эх бичвэрүүд нь адил хүчинтэй байх бөгөөд эх бичвэрүүдийг Эх хадгалагчид хадгалуулна. Эх хадгалагч нь эх бичвэрүүдийн баталгаат хуулбарыг Хэлэлцэн тохиролцогч талуудад хүргүүлнэ.





**МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ  
ЦӨМИЙН МАТЕРИАЛЫГ БИЕЧЛЭН ХАМГААЛАХ ТУХАЙ  
КОНВЕНЦЫН 2005 ОНЫ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

1. 1979 оны 10 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан “Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц” (цаашид “конвенц” гэх)-ийн нэрийг “Цөмийн байгууламж болон цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц” хэмээн өөрчлөв.

2. Энэхүү конвенцын Удиртгал хэсгийг дараах бичвэрээр өөрчлөв.

Үүнд:

**ЭНЭХҮҮ КОНВЕНЦОД ОРОЛЦОГЧ УЛСУУД,**

Цөмийн энергийг энхийн зорилгоор хөгжүүлж, ашиглах бүх улсын эрх болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашигласнаас бий болох бодит ашиг тусыг хүртэхэд чиглэсэн тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч,

Цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах олон улсын хамтын ажиллагааг дэмжих, энэ чиглэлээр цөмийн технологийг дамжуулах шаардлагатай байгаад итгэж,

Үндэсний болон олон улсын аюулгүй байдал, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалахад цөмийн материалыг биечлэн хамгаалах нь амин чухал ач холбогдолтойг анхаарч,

Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах, улс орнуудын хоорондын найрсаг, сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагааг дэмжихийг эрхэмлэсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн зорилго, зарчмыг анхааралдаа авч,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүх гишүүн нь олон улсын харилцаандаа аливаа улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, эсхүл улс төрийн тусгаар тогтнолын эсрэг хүчээр сүрдүүлэх болон хүч хэрэглэх, түүнчлэн Нэгдсэн Үндэстний зорилгод харшлах аливаа бусад үйлдлийг цээрлэнэ” гэж заасныг харгалзаж,

Ерөнхий Ассамблейн 1994 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 49/60 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Олон улсын терроризмыг устгах арга хэмжээний тухай тунхаглалыг эргэн санаж,



Цөмийн материалыг хууль бусаар олж авах, ашиглах, хууль бусаар хил нэвтрүүлэх, цөмийн байгууламж болон цөмийн материалыг хорлон сүйтгэх ажиллагаанд ашигласнаас үүсэж болох аюулаас сэрэмжлэхийг эрмэлзэн, эдгээр үйлдлийн эсрэг биечлэн хамгаалалт хийхэд үндэсний болон олон улсын түвшинд улам бүр анхаарал хандуулах шаардлагатай асуудал болоод буйг тэмдэглэж,

Дэлхий дахинд бүх хэлбэр, байдлаар өсөн нэмэгдэж буй террорист үйлдэл, олон улсын терроризм ба зохион байгуулалттай гэмт хэргийн улмаас учрах аюул заналд санаа зовниж,

Биечлэн хамгаалалт нь терроризмтой тэмцэх, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх зорилгыг биелүүлэхэд чухал үүрэгтэй гэдэгт итгэж,

Энэхүү конвенцоор дамжуулан энхийн зорилгоор ашиглаж буй цөмийн материал болон цөмийн байгууламжийн биечлэн хамгаалалтыг дэлхий дахинаа бэхжүүлэхийг эрмэлзэж,

Цөмийн материал болон цөмийн байгууламжтай холбогдсон гэмт үйлдэл бол сэтгэл түгшээсэн ноцтой асуудал бөгөөд ийм гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх үр дүнтэй зохих арга хэмжээг авах, эсхүл хүчин төгөлдөр үйлчилж буй арга хэмжээг бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаад итгэж,

Оролцогч Улс бүрийн үндэсний хууль тогтоомж, мөн энэхүү конвенцод нийцүүлэн цөмийн материал болон цөмийн байгууламжийн биечлэн хамгаалалтын үр дүнтэй арга хэмжээг бий болгох зорилгоор олон улсын хамтын ажиллагааг улам бүр бэхжүүлэхийг эрмэлзэж,

Энэхүү конвенц нь цөмийн байгууламжийн аюулгүй ажиллагаа, цөмийн материалыг аюулгүй ашиглах, хадгалах, тээвэрлэхэд хувь нэмэр оруулна гэдэгт итгэж,

Олон улсын түвшинд биечлэн хамгаалалтын зөвлөмжүүд боловсруулагдсан бөгөөд эдгээр зөвлөмжүүд нь үр дүнтэй биечлэн хамгаалалтын түвшинд хүрэх орчин үеийн арга хэрэгслийг тусган тухай бүр шинэчлэгдэж байгааг хүлээн зөвшөөрч,

Цэргийн зорилгоор ашиглаж буй цөмийн материал болон цөмийн байгууламжийг үр дүнтэй биечлэн хамгаалах нь тухайн цөмийн материал болон цөмийн байгууламж эзэмшигч улсын үүрэг бөгөөд эдгээр материал байгууламжийг хатуу чанд биечлэн хамгаалалт доор байлгах, цаашид энэ хэвээр байлгах ёстойг хүлээн зөвшөөрч,

Дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов.

3. Конвенцын 1 дүгээр зүйлд, (с) хэсгийн доор шинээр дараах хоёр заалтыг нэмэв. Үүнд:

(d) “цөмийн байгууламж” гэж цөмийн материалыг үйлдвэрлэх, боловсруулах, ашиглах, зөөвөрлөх, хадгалах, эсхүл булшлах зориулалттай, гэмтэл үүссэн тохиолдолд их хэмжээний цацраг, эсхүл цацраг идэвхт материал алдагдах боломжтой байгууламж (холбогдох барилга болон тоног төхөөрөмж орно)-ийг хэлнэ;

(e) “хорлон сүйтгэх ажиллагаа” гэж цөмийн байгууламж, эсхүл цөмийн материалыг ашиглах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааны эсрэг чиглэсэн, шууд ба шууд бусаар цацрагтай ажиллагчдын аюулгүй байдал, эрүүл мэнд, хүн ам болон хүрээлэн буй орчинд цацрагийн шарлага үзүүлэх, эсхүл цацраг идэвхт бодисыг тархаах аливаа санаатай үйлдлийг хэлнэ.

4. Конвенцын 1 дүгээр зүйлийн дараа шинээр 1А дугаар зүйлийг нэмэв. Үүнд:

#### 1А дугаар зүйл

Энэхүү конвенцын зорилго нь дэлхий дахинд энхийн зорилгоор ашиглаж буй цөмийн байгууламж болон цөмийн материалын үр дүнтэй биечлэн хамгаалалтыг бий болгож хэвшүүлэх; энэхүү цөмийн материал болон байгууламжийн эсрэг гэмт хэрэг үйлдэхээс дэлхий нийтээр урьдчилан сэргийлэх; түүнтэй тэмцэх, чиглэлээр Оролцогч Улсуудын хамтын ажиллагааг дэмжихэд оршино.

5. Конвенцын 2 дугаар зүйлийг дараах бичвэрээр өөрчлөв. Үүнд:

1.Энэхүү конвенцыг энхийн зорилгоор ашиглаж, хадгалж, тээвэрлэж буй цөмийн материал болон энхийн зорилгоор ашиглаж буй цөмийн байгууламжийн хувьд хэрэглэнэ. Гэхдээ энэхүү конвенцын 3, 4 дүгээр зүйл болон 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь гагцхүү олон улсын цөмийн тээвэрлэлтэд байгаа цөмийн материалын хувьд үйлчилнэ.

2.Оролцогч Улсын нутаг дэвсгэрт биечлэн хамгаалалтын дэглэмийг бий болгох, хэрэгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах үүргийг гагцхүү тухайн улс хүлээнэ.

3.Энэхүү конвенцын хүрээнд Оролцогч Улсуудын тодорхой илэрхийлэн хүлээсэн үүрэг амлалтаас бусад энэхүү конвенцын аль ч заалтыг тухайн улсын бүрэн эрхийг хөндөж байна гэж тайлбарлахгүй.



4.(а) Энэхүү конвенцын аль ч заалт Оролцогч Улсуудын олон улсын эрх зүйгээр хүлээсэн, үүний дотор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн зорилго, зарчим болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагыг хөндөхгүй.

(b) Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хүрээнд тодорхойлсон, түүгээр зохицуулагддаг зэвсэгт мөргөлдөөний үеийн зэвсэгт хүчний үйл ажиллагаа энэхүү конвенцын үйлчлэлд хамаарахгүй. Мөн тухайн улсын зэвсэгт хүчний албан үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь олон улсын эрх зүйн бусад дүрэм, журмаар зохицуулагдаж байгаа нөхцөлд энэхүү конвенцын үйлчлэлд хамаарахгүй.

(c) Энэхүү конвенцын аль ч заалтыг энхийн зорилгоор ашиглаж буй цөмийн материал болон цөмийн байгууламжийн эсрэг хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх хууль ёсны эрх олгож байгаа мэтээр ойлгож болохгүй.

(d) Энэхүү конвенцын аль ч заалт хууль бус үйлдлийг зөвтгөх, эсхүл хууль ёсны хэмээн тооцоход үл хүргэх ба тухайн үйлдэлд бусад эрх зүйн хүрээнд хариуцлага оногдуулахад саад болохгүй.

5.Энэхүү конвенц цэргийн зориулалтаар ашигласан болон хуримтлуулсан цөмийн материал, эсхүл тухайн материалыг агуулсан цөмийн байгууламжийн хувьд хамаарахгүй.

6.Конвенцын 2 дугаар зүйлийн дараа шинээр 2А дугаар зүйлийг нэмэв.

#### 2А дугаар зүйл

1.Оролцогч Улс бүр дараах зорилгоор өөрийн харьяалалд байгаа цөмийн байгууламж болон цөмийн материалын зөв зохистой биечлэн хамгаалах дэглэмийг бий болгох, хэрэгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээ авна. Үүнд:

(а) ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтэд буй цөмийн материалыг хууль бусаар олж авах, хулгайлахаас сэргийлэх;

(b) алдагдсан, эсхүл хулгайлагдсан цөмийн материалын байршлыг тогтоох, боломжтой бол эгүүлэн олж авах шуурхай, цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хэрэв материал нь тухайн улсын нутаг дэвсгэрийн гадна байрлаж буй бол тус Оролцогч Улс 5 дугаар зүйлд заасны дагуу арга хэмжээ авна;

(c) цөмийн байгууламж болон цөмийн материалыг хорлон сүйтгэх ажиллагаанаас хамгаалах;



(d) хорлон сүйтгэх ажиллагааны улмаас үүсэх цацрагийн хор хөнөөлийг арилгах, эсхүл бууруулах.

2.Оролцогч Улс бүр 1 дэх хэсгийн заалтыг хэрэгжүүлэхдээ:

(a) биечлэн хамгаалалтыг зохицуулах эрх зүйн болон хяналтын тогтолцоог бий болгож, хэвийн үйл ажиллагааг хангах;

(b) эрх зүйн болон хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, эсхүл байгууллагуудыг байгуулах, эсхүл томилох;

(c) цөмийн материал болон байгууламжуудыг биечлэн хамгаалахад шаардлагатай холбогдох бусад арга хэмжээг авна.

3.Конвенцын 1 болон 2 дугаар зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэхдээ Оролцогч Улс бүр конвенцын бусад аливаа заалтыг хөндөхгүйгээр цөмийн материал болон цөмийн байгууламжийн биечлэн хамгаалалтын дараах үндсэн зарчмуудыг зохих түвшинд бололцооны хэрээр мөрдөнө.

#### **ҮНДСЭН ЗАРЧИМ А:** *Улсын хүлээх үүрэг, хариуцлага*

Тухайн улсад биечлэн хамгаалалтын дэглэмийг бий болгох, хэрэгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг, хариуцлагыг гагцхүү тухайн улс хүлээнэ.

#### **ҮНДСЭН ЗАРЧИМ В:** *Олон улсын тээвэрлэлтийн үед хүлээх үүрэг, хариуцлага*

Цөмийн материалыг зохих ёсоор хамгаалах үүрэг хүлээсэн улс нь тухайн материалыг олон улсад тээвэрлэх үед дээрхийн нэгэн адил үүрэг хүлээх бөгөөд уг үүргээ өөр улсад зохих ёсоор шилжүүлэх хүртэл энэ үүргээ хэрэгжүүлнэ.

#### **ҮНДСЭН ЗАРЧИМ С:** *Эрх зүйн болон хяналтын тогтолцоо*

Тухайн улс нь биечлэн хамгаалалтын асуудлыг зохицуулсан эрх зүйн болон хяналтын тогтолцоог бий болгох, хэвийн үйл ажиллагааг хангаж хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэхүү тогтолцоогоор биечлэн хамгаалалтын холбогдох шаардлагуудыг тогтоохын зэрэгцээ тусгай зөвшөөрөл олгох, эсхүл үнэлгээ хийх тогтолцоо, эсхүл зөвшөөрөл олгохтой холбоотой бусад журмыг бий болговол зохино. Энэ тогтолцооны хүрээнд цөмийн байгууламжууд болон тээвэрлэлтийн горим нь холбогдох тусгай зөвшөөрөл, эсхүл бусад зөвшөөрөл олгох баримт бичигт тавигдах нөхцөл, шаардлагад нийцэж буй эсэхийг баталгаажуулах, түүнчлэн эдгээр шаардлага,

нөхцөлийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл, үр дүнтэй хариуцлагын арга хэмжээг бий болгох хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлсэн байна.

**ҮНДСЭН ЗАРЧИМ D: Эрх бүхий байгууллага**

Улс нь эрх зүйн болон хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх чиг үүрэгтэй, тэрхүү чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд зохих удирдлага, эрх хэмжээ, санхүү, хүний нөөцөөр хангагдсан эрх бүхий байгууллагыг томилох, эсхүл байгуулна. Улс нь тухайн улсын эрх бүхий байгууллага болон цөмийн энергийг ашиглах, эсхүл хэрэглээг хөхиүлэн дэмжих асуудал эрхэлсэн аливаа бусад байгууллага чиг үүргийн хувьд бие биеэсээ хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах арга хэмжээ авна.

**ҮНДСЭН ЗАРЧИМ E: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг, хариуцлага**

Тухайн улсад мөрдөх биечлэн хамгаалалтын төрөл бүрийн горимыг хэрэгжүүлэхтэй холбоотой үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлсон байна. Улс нь цөмийн материал, эсхүл цөмийн байгууламжийг эзэмших тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсхүл бусад зөвшөөрлийн баримт бичиг (операторын, эсхүл тээвэрлэгчийн гэх мэт)–ийг эзэмшигч этгээд тухайн байгууламж болон материалын биечлэн хамгаалалтыг хангах үндсэн үүрэг хариуцлага хүлээдэг байх нөхцөлийг хангана.

**ҮНДСЭН ЗАРЧИМ F: Аюулгүй байдлын соёл**

Биечлэн хамгаалалтыг хэрэгжүүлэхэд оролцож буй бүх байгууллагууд түүнийг байгууллагынхаа хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд аюулгүй байдлыг хангах соёлыг бий болгож, хэвшүүлэхэд онцгойлон анхаарах ёстой.

**ҮНДСЭН ЗАРЧИМ G: Аюул занал**

Улс нь биечлэн хамгаалалтыг бий болгохдоо тухайн үеийн аюул заналын үнэлгээг үндэслэнэ.

**ҮНДСЭН ЗАРЧИМ H: Шаталсан арга зам**

Биечлэн хамгаалалтын шаардлагыг тогтоохдоо цөмийн материалыг зөвшөөрөлгүйгээр зөвөөрлөх болон цөмийн материал, эсхүл цөмийн байгууламжийн эсрэг хорлон сүйтгэх ажиллагаа явуулснаас үүдэн гарч болзошгүй үр дагавар, материалын шинж чанар, ашиглагдах байдал, аюул заналыг үнэлсэн үнэлгээг харгалзах замаар шаталсан арга замаар тогтоовол зохино.

**ҮНДСЭН ЗАРЧИМ I:** *Нарийвчилсан хамгаалалт*

Тухайн улсын биечлэн хамгаалалтын шаардлагыг тогтоохдоо хорлон сүйтгэгч этгээд өөрийн зорилгыг гүйцэлдүүлэхийн тулд тулгарах, эсхүл давж гарах шаардлагатай болох хэд хэдэн давхар хамгаалалтын бүс, арга (бүтцийн, эсхүл бусад техникийн шинжтэй, боловсон хүчний болон байгууллагын)-ыг тусгасан байна.

**ҮНДСЭН ЗАРЧИМ J:** *Чанарын баталгаа*

Биечлэн хамгаалалтад шаардлагатай бүхий л үйл ажиллагаанд тавигдах тусгайлсан шаардлагыг хангах үүднээс чанарын баталгааны бодлого болон хөтөлбөрийг бий болгож, хэрэгжүүлнэ.

**ҮНДСЭН ЗАРЧИМ K:** *Гэнэтийн үеийн арга хэмжээний төлөвлөгөө*

Холбогдох эрх бүхий байгууллага болон бүх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цөмийн материалыг зөвшөөрөлгүйгээр зөөвөрлөх, эсхүл цөмийн материал болон цөмийн байгууламжийн эсрэг хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, эсхүл тийнхүү завдах үед авах гэнэтийн үеийн (онцгой байдлын) арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, зохих ёсоор хэрэгжүүлж ажиллана.

**ҮНДСЭН ЗАРЧИМ L:** *Нууцлал*

Тухайн улс нь цөмийн байгууламж болон цөмийн материалын биечлэн хамгаалалтад эрсдэл учруулж болзошгүй мэдээллийг зөвшөөрөлгүйгээр задруулахаас сэргийлж мэдээллийн нууцлалыг хамгаалахтай холбоотой шаардлагыг бий болгоно.

4.(a) Оролцогч Улсын зүгээс аливаа цөмийн материалын шинж чанар, хэмжээ, ашиглагдах байдал, түүний эсрэг чиглэсэн хууль бус үйлдлийн улмаас үүсэж болзошгүй цацрагийн болон бусад үр дагавар, мөн тухайн үеийн аюул заналын үнэлгээг харгалзсаны үндсэн дээр тухайн цөмийн материалыг 1 дэх хэсэгт заасан биечлэн хамгаалалтад хамруулахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэхүү зүйлийн заалтууд уг цөмийн материалын хувьд үйлчлэхгүй.

(b) дээрх (a) дэд хэсэгт зааснаар энэхүү зүйлийн заалт үл үйлчлэх цөмийн материалыг менежментийн нарийн практик ажиллагааны дагуу хамгаална.

7.Конвенцын 5 дугаар зүйлийг дараах бичвэрээр өөрчлөв.



1.Оролцогч Улсууд энэхүү конвенцтой холбоотой асуудлаар холбоо барих этгээдийг томилж, өөр хоорондоо шууд, эсхүл Олон улсын атомын энергийн агентлагаар дамжуулан мэдэгдэнэ.

2.Цөмийн материалыг хулгайлах, дээрмийн, эсхүл аливаа хууль бус замаар булаан авах болон ийм үйлдэл учирч болох бодит аюулын үед цөмийн материалыг эгүүлэн олж авах, хамгаалуулах талаар хүсэлт тавьсан аливаа улстай Оролцогч Улсууд үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу аль болох бололцооны хэрээр хамтран ажиллаж, туслалцаа үзүүлнэ. Тухайлбал:

(a) цөмийн материалыг хулгайлах, дээрэмдэх, эсхүл аливаа хууль бус замаар булаан авах болон ийм үйлдэл учирч болох бодит аюулын тухай Олон улсын атомын энергийн агентлаг болон холбогдолтой гэж үзсэн бусад олон улсын байгууллагад аль болох яаралтай мэдэгдэх талаар Оролцогч Улс зохих арга хэмжээ авна;

(b) дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ шаардлагатай бол холбогдох Оролцогч Улсууд алдагдах аюулд байгаа цөмийн материалыг хамгаалах, тээврийн чингэлгийн бүрэн бүтэн байдлыг шалгах, эсхүл хууль бусаар булаан авсан цөмийн материалыг эгүүлэн олж авахын тулд өөр хоорондоо, эсхүл Олон улсын атомын энергийн агентлаг болон бусад холбогдох олон улсын байгууллагатай мэдээлэл солилцох бөгөөд;

(i) өөрсдийн хүчин чармайлтыг дипломат болон харилцан тохиролцсон бусад шугамаар зохицуулна;

(ii) хүсэлт тавьсан үед туслалцаа үзүүлнэ;

(iii) дээр дурдсан үйлдлийн улмаас хулгайлагдсан, эсхүл алга болсон цөмийн материалыг эгүүлэн олж авах явдлыг хангана.

Ийм хамтын ажиллагааг хэрэгжүүлэх арга замыг холбогдох Оролцогч Улсууд тодорхойлон тогтооно.

3.Цөмийн материал болон цөмийн байгууламжийн эсрэг хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулж болзошгүй өндөр магадлалтай заналхийлэл, эсхүл хорлон сүйтгэх үйл ажиллагаа болсон тохиолдолд Оролцогч Улсууд өөрийн үндэсний хууль тогтоомж болон олон улсын эрх зүйн хүрээнд хүлээсэн үүргийнхээ дагуу аль болох бололцооны хэрээр дараах байдлаар хамтран ажиллана. Үүнд:

(a) хэрэв Оролцогч Улс өөр нэг улсын цөмийн материал болон цөмийн байгууламжтай холбоотой хорлон сүйтгэх ажиллагааны явагдаж





болзошгүй тухай мэдээлэлтэй байвал уг хорлон сүйтгэх ажиллагааг таслан зогсоох зорилгоор тухайн улсад аль болох шуурхай мэдэгдэх, шаардлагатай бол Олон улсын атомын энергийн агентлаг болон бусад олон улсын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх зохих арга хэмжээ авна;

(b) Оролцогч Улсад байгаа цөмийн материал болон цөмийн байгууламжийн эсрэг хорлон сүйтгэх ажиллагаа явагдсан бөгөөд хэрэв бусад улс түүний цацрагийн нөлөөнд өртөх магадлалтай байвал тухайн Оролцогч Улс цацрагийн үр дагаврыг багасгах, эсхүл арилгах зорилгоор олон улсын эрх зүйгээр хүлээсэн бусад үүрэгтээ харшлахгүйгээр цацрагт өртөх магадлалтай улсуудад аль болох яаралтай мэдэгдэх, шаардлагатай бол Олон улсын атомын энергийн агентлаг болон бусад олон улсын байгууллагад мэдэгдэх арга хэмжээ авна;

(c) хэрэв (a) болон (b) дэд хэсэгт дурдсан нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан Оролцогч Улс тусламж хүссэн тохиолдолд хүсэлт хүлээн авсан Оролцогч Улс бүр тэрхүү тусламжийг үзүүлэх бололцоотой эсэх болон үзүүлэх тусламжийн хамрах хүрээ, нөхцөлийн талаар тухайн улсад шууд, эсхүл Олон улсын атомын энергийн агентлагаар дамжуулан шуурхай мэдэгдэнэ;

(d) (a)-гаас (c) дэд хэсэгт дурдсан хамтын ажиллагааг дипломат шугамаар, эсхүл харилцан тохиролцсон бусад сувгаар дамжуулан зохицуулна. Энэхүү хамтын ажиллагааг хэрэгжүүлэх арга хэрэгслийг холбогдох Оролцогч Улсууд хоёр талт, эсхүл олон талт хамтын ажиллагааны хүрээнд тодорхойлно.

4.Оролцогч Улсууд цөмийн материалыг олон улсад тээвэрлэх явцад түүнийг биечлэн хамгаалах тогтолцоог загварчилж боловсруулах, хэвийн үйл ажиллагааг хангах, сайжруулах талаар зохих зааварчилгаа авах зорилгоор өөр хоорондоо шууд, эсхүл Олон улсын атомын энергийн агентлаг болон бусад олон улсын байгууллагуудаар дамжуулан зөвлөлдөж, хамтран ажиллана.

5.Оролцогч Улс дотооддоо хэрэглэж буй цөмийн материалын ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт болон цөмийн байгууламжийн биечлэн хамгаалалтын үндэсний тогтолцоог загварчилж боловсруулах, хэвийн үйл ажиллагааг хангах, сайжруулах талаар зохих зааварчилгаа авах зорилгоор өөр хоорондоо шууд, эсхүл Олон улсын атомын энергийн агентлаг болон холбогдох бусад олон улсын байгууллагуудаар дамжуулан зөвлөлдөж, хамтран ажиллана.

8.Конвенцын 6 дугаар зүйлийг дараах бичвэрээр өөрчлөв.

1.Оролцогч Улсууд энэхүү конвенцын дагуу буюу энэхүү конвенцыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох замаар оролцогч нөгөө улсаас итгэмжлэн хүлээж авсан аливаа мэдээллийн нууцыг хадгалахын тулд өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээг авна. Хэрэв Оролцогч Улсууд олон улсын байгууллагуудад болон энэхүү конвенцод оролцогч бус улсад мэдээллийг итгэмжлэн дамжуулсан бол уг мэдээллийн нууцлалыг хамгаалахад шаардлагатай арга хэмжээг авна. Тухайн Оролцогч Улс нь өөр Оролцогч Улсаас авсан нууц мэдээллийг зөвхөн тухайн Оролцогч Улсын зөвшөөрөлтэйгөөр гуравдагч талд дамжуулна.

2.Энэхүү конвенцоор холбогдох улсын аюулгүй байдал, цөмийн байгууламж болон цөмийн материалыг биечлэн хамгаалахад аюул занал учруулж болох, эсхүл хууль тогтоомжоор нь зөвшөөрөөгүй аливаа мэдээллийг гаргаж өгөхийг Оролцогч Улсуудаас шаардаагүй болно.

9.Конвенцын 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дараах бичвэрээр өөрчлөв.

1.Санаатайгаар:

(a) хүний амь нас хохироох, эсхүл хүнд гэмтэл учруулсан, эсхүл өмч хөрөнгө, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулсан, эсхүл учруулж болох цөмийн материалыг хүлээж авах, эзэмших, ашиглах, дамжуулах, хэлбэрийг нь өөрчлөх, устгах, эсхүл цацаж сарниулах үйлдлийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр үйлдсэн;

(b) цөмийн материалыг хулгайлах, эсхүл дээрэмдэх замаар булаан авсан;

(c) хууран мэхлэх замаар цөмийн материалыг олж авсан, эсхүл завшсан;

(d) эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр цөмийн материалыг зөөвөрлөх, илгээх, эсхүл тухайн улс руу оруулах, гаргах үйлдэл хийсэн;

(e) гэмт этгээд нутаг дэвсгэрт нь цөмийн байгууламж байрлаж байгаа Оролцогч Улсын үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн тийнхүү гүйцэтгэснээс бусад тохиолдолд тухайн цөмийн байгууламжийн эсрэг чиглэсэн үйлдэл хийж, эсхүл уг байгууламжийн үйл ажиллагааг тасалдуулан цацрагийн шарлагад өртүүлэх, цацраг идэвхт бодисыг гадагшлуулах замаар хүний амь нас хохироох, хүнд гэмтэл учруулах, эсхүл өмч хөрөнгө, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулж болох санаатай үйлдэл хийсэн;



(f) хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл айлган сүрдүүлэх, эсхүл аливаа бусад хэлбэрээр цөмийн материал өгөхийг шаардсан үйлдэл;

(g) доор дурдсанаар заналхийлсэн:

(i) хүний амь насыг хохироох, эсхүл хүнд гэмтэл учруулах, өмч хөрөнгө, эсхүл хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулах, эсхүл “е” дэд хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэх цөмийн материал ашиглахаар;

(ii) аливаа үйлдэл үйлдэх, эсхүл түүнээс түдгэлзэхийг хувь хүн болон хуулийн этгээд, олон улсын байгууллага, эсхүл улсад тулган шаардах зорилгоор (b) болон (e) дэд хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэхээр;

(h) (a)-гаас (e) дэд хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэхийг завдсан;

(i) (a)-гаас (h) дэд хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэхэд оролцсон;

(j) (a)-гаас (h) дэд хэсэгт заасан гэмт хэргийг зохион байгуулсан, эсхүл уг гэмт хэрэг үйлдэхийг бусдад зааварласан;

(k) нэгдмэл зорилготой бүлэг этгээд (a)-гаас (h) дэд хэсэгт заасан аль нэг гэмт хэргийг санаатай бөгөөд:

(i) (a)-аас (g) дэд хэсэгт заасан үйлдэхэд чиглэсэн эрүүгийн зорилго, үйл ажиллагааг ахиулах зорилготой үйлдсэн; эсхүл

(ii) (a)-аас (g) дэд хэсэгт заасан гэмт хэргийг тухайн бүлэглэл нь санаатайгаар үйлдсэн

бол Оролцогч Улс бүр үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэмт хэрэгт тооцох арга хэмжээг авна.

10.Конвенцын 11 дүгээр зүйлийн дараа шинээр 11А болон 11В дүгээр зүйлүүдийг дараах байдлаар нэмэв.

11А дугаар зүйл

7 дугаар зүйлд дурдсан аль ч гэмт хэргийг улс төрийн гэмт хэрэг, улс төрийн гэмт хэрэгтэй холбоотой гэмт хэрэг, аль эсхүл улс төрийн сэдэлтэй гэмт хэрэгт хамааруулж гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх, эсхүл эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх зорилгоор ашиглахгүй. Чингэхдээ тухайн гэмт



хэрэг нь улс төрийн гэмт хэрэг, улс төрийн гэмт хэрэгтэй холбоотой гэмт хэрэг, эсхүл улс төрийн сэдэлтэй гэмт хэрэгтэй холбоотой гэсэн ганцхан үндэслэлээр уг гэмт хэрэгт холбогдсон гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх, эсхүл эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлтийг татгалзаж болохгүй.

#### 11В дүгээр зүйл

Хэрэв хүсэлт хүлээн авсан Оролцогч Улс 7 дугаар зүйлд дурдсан гэмт хэрэгтэй холбогдуулан гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх, эсхүл эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлт нь хүнийг арьсны өнгө, шашин шүтлэг, үндэс, угсаа, эсхүл улс төрийн үзэл бодлынх нь үүднээс яллаж, шийтгэх зорилгоор гаргасан, эсхүл уг хүсэлтийг биелүүлэх нь дээр дурдсан аль нэг үндэслэлээр тухайн хүнийг алагчлахад хүргэнэ гэж үзэх бодит үндэслэл байвал энэхүү конвенцын аль ч заалтыг гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх, эсхүл эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үүрэг хүлээсэн мэтээр тайлбарлаж үл болно.

11.Конвенцын 13 дугаар зүйлийн дараа шинээр 13А дугаар зүйлийг нэмэв.

#### 13А дугаар зүйл

Энэхүү конвенцын аль ч заалт цөмийн байгууламж болон цөмийн материалын биечлэн хамгаалалтыг бэхжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй энхийн зорилго бүхий цөмийн технологийг дамжуулахад нөлөөлөхгүй.

12.Конвенцын 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг дараах бичвэрээр өөрчлөв.

3.Гэмт хэрэг тухайн улсад ашиглаж, хадгалж, тээвэрлэж буй цөмийн материалыг ашиглан үйлдэгдсэн бөгөөд сэжигтэн этгээд болон цөмийн материалын аль аль нь гэмт хэрэг гарсан Оролцогч Улсын нутаг дэвсгэрт байгаа, эсхүл гэмт хэрэг нь цөмийн байгууламжтай холбоотойгоор гарсан бөгөөд сэжигтэн этгээд гэмт хэрэг гарсан Оролцогч Улсын нутаг дэвсгэрт байгаа нөхцөлд энэхүү конвенцын аль ч заалт уг гэмт хэргийн талаарх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээ гаргаж өгөхийг холбогдох Оролцогч Улсаас шаардаж буй мэтээр тайлбарлаж үл болно.

13.Конвенцын 16 дугаар зүйлийг дараах бичвэрээр өөрчлөв.

1. 2005 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан конвенцын нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн дараа



энэхүү конвенцын хэрэгжилт, түүний удиртгал, үндсэн хэсэг болон хавсралт нь тухайн үеийн нөхцөл байдлын шаардлагад хэрхэн нийцэж байгааг хэлэлцэх зорилгоор Оролцогч Улсуудын бага хурлыг эх хадгалагч зарлан хуралдуулна.

2.Цаашид конвенцод Оролцогч Улсуудын олонх нь эх хадгалагчид зохих саналаа тавих замаар, дээр дурдсан зорилгоор дараа дараагийн бага хурлыг таван жилд нэг удаа зарлан хуралдуулж болно.

14.Конвенцын II дугаар Хавсралтын нэмэлт тайлбар b-г дараах байдлаар өөрчлөв.

<sup>b/</sup> Цацрагийн түвшин нь хамгаалалтгүйгээр 1 метр зайд 1 Гр/цаг (100 рад/цаг)-тай тэнцүү, эсхүл түүнээс бага байх реакторт шарагдсан, эсхүл шарагдаагүй материал.

15.Хавсралт II-ын нэмэлт тайлбар e- г дараах бичвэрээр өөрчлөв.

<sup>e/</sup> Шарагдахын өмнө анхны хуваагдлын материалын хувьд I ба II дугаар ангилалд орсон бусад түлшийг цацрагийн түвшин нь хамгаалалтгүйгээр 1 метр зайд 1 Гр/цаг (100 рад/цаг)-аас их байх үед нэг ангиллаар бууруулж болно.

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medecelel@parliament.mn](mailto:turiin_medecelel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 8.25

**Индекс:** 200003